**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

# Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг
# Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000

**MNS 6703:2017**

**Албан хэвлэл**

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**
**УЛААНБААТАР ХОТ**
**2017 он**

**ӨМНӨХ ҮГ**

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон Улсын Стандартчиллын Байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж гишүүдийн 75%–иас доошгүй дэмжиж, зөвшилцсөн төслийг Стандартчиллын Үндэсний Зөвлөл (СҮЗ)–өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.
Энэ стандартыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын, Геодези, зураг зүйн хэлтсээс санаачлан боловсруулсан.

Стандарт боловсруулах судалгааг ГЗБГЗЗГ-ын Геодези, зураг зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарзаяа, Архив, мэдээллийн төвийн ахлах мэргэжилтэн Л.Мандхай нар хийж, хэлбэржүүлсэн.

Стандартын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, ГХГЗЗГ-ын /хуучин нэрээр/ даргын дэргэдэх хурал болон орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-ийн хамт олон болон ГЗЗХ-ийн дарга Монгол улсын зөвлөх инженер С.Энхтуяа, Монгол улсын зөвлөх инженер Ю.Чүлтэм, Монгол улсын зөвлөх инженер Г.Нарантуяа болоод бусад үнэтэй санал зөвлөгөө өгсөн геодези, зураг зүйн салбарын хамт олонд талархаж байна.

СХЗГ-ын стандартын шинжээч Н.Батжаргал “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006“ стандарттай нийцүүлэн хянасан.

Стандарт, хэмжил зүйн газрын “Газрын салбарын стандартчиллын техникийн хороо /ТХ-36/”-ны хуралдаанаар хэлэлцүүлэн стандарт болгон батлуулах нь зүйтэй хэмээн дэмжсэн.

**Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)**
Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар 13348, ШХ-48
Утас: 266754, 263860,
Факс: (976-11) 458032
E-mail: standardinform@masm.gov.mn
Вэб сайт:www.estandard.gov.mn,
www.masm.gov.mn

**© СХЗГ, 2017**

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандарчиллын Төв байгууллага)-т байна.

# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . ii

ОРШИЛ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . iv

1 Хамрах хүрээ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 1

2 Норматив эшлэл . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 1

3 Нэр томьёо, тодорхойлолт . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 1

4 Норматив шаардлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 1

5 Таних тэмдэгт тавих ерөнхий шаардлага . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 2

6 Таних тэмдгийн бичиглэлд тавих шаардлага . . . . . . . . . . . . . . . . . . . . 3

7 Таних тэмдэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 4

8 Таних тэмдгийн тайлбар, түүнд тавигдах шаардлага . . . . . . . . . . . . . . . . . . . . 14

9 Загвар сангийн ангилал, давхаргын жагсаалт . . . . . . . . . . . . . . . . . . . 35

10 Загвар сангийн давхаргын талбарын монгол тайлбар . . . . . . . . . . . . . . 44

11 Загвар санд тодорхойлогдсон домэйн утгууд . . . . . . . . . . . . . . 45

12 Таних тэмдэгт хэрэглэх өнгөний кодлол . . . . . . . . . . . . . . . . . . . 46

Нэмэлт мэдээлэл

/Байр зүйн зурагт үгийг хураангуйлан бичих заавар/ . . . . . . . . . . . . . . . . . . . 47

# ОРШИЛ

1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн загвар сан, таних тэмдгийг “Байр зүйн 1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай зургийн томьёолсон тэмдэг” ном, Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн загвар, кодчилол /БНСУ-ын инженерүүдтэй хамтран боловсруулсан/, дэлхийн 30-аад оронд хэрэглэгддэг байр зүйн зургийн мэдээллийн сан түүний загвар зэргийг ашиглан Монгол улсад байр зүйн зураг зохиоход ашиглах стандарт болгож боловсруулллаа.

Уг стандартад байр зүйн зурагт дүрслэх элементүүдийг 26 ангилан цаашид нэмэх бололцоотой байдлаар хийсэн. Ангилал тус бүр өөртөө байр зүйн зурагт дүрслэгдэх элементүүдийг агуулсан бөгөөд элемент бүр өөр өөрийн хүснэгтэн мэдээлэлтэй хийгдсэн нь цаашид орон зайн мэдээллийн суурь болгон байр зүйн зургийг ашиглах бололцоог бүрдүүлж өгч байгаа юм.

Таних тэмдгийг масштаб тус бүрт зураглагдах байдлаар хүснэгтээр үзүүлж, загвар сангийн бүтэц ангилал, талбарын төрөл, тэмдэгтийн утга зэргийг тодорхой үзүүлсний дээр домэйн утгыг шаардлагатай элементүүдэд тодорхойлж өгсөн. Элемент бүрт тайлбар байх бөгөөд барилга, байшин дээр нэмэлтээр тэмдэглэгдэж буй зарим элементүүд хэрэглэгчдэд байр зүйн зургаас тодорхой мэдээлэл авах болон орон зайн мэдээллийн бааз байгуулахад ашиглагдах зорилго агуулж байгаа юм. Мөн таних тэмдгийн өнгө, хэмжээг тодорхойлж, өнгийг хар, улаан, цэнхэр, ногоон, шар, ягаан буюу цэг, шугам, талбайн элементээр кодолсон нь байр зүйн зураг нэг загвар, стандартаар хийгдэх шаардлагыг хангаж байгаа юм.

Таних тэмдгийг Arc GIS программд танигдах **Style file** болгож үүсгэсэн нь хэрэглэгчдэд тухайн файлыг шууд холбон вектор өгөгдлийг код тус бүрээр нь автоматаар таних тэмдэгжүүлэн байр зүйн тоон зургийг хялбархан гаргаж авах бололцоог бүрдүүлж өгсөн.

Байр зүйн зураг хийж буй бүх хэрэглэгчид загвар сан, таних тэмдгийн **style file**-ийн ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-тэй холбогдож авах буюу тодруулга авч болно.

Энэ стандарт нь том масштабын байр зүйн болон дэвсгэр зураг зохиоход дагаж мөрдөх Монгол улсын албан ёсны анхны стандарт болно.

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Ангилалтын код 01.080.30; 07.040; 35.240.70**

| | |
|---|---|
| **Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000.** | **MNS 6703:2017** |
| **Topographic map database design, symbols Scale: 1:25 000, 1:50 000, 1:100 000.** | |

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Хамрах хүрээ

Монгол улсын хэмжээнд 1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг зохиох, шинэчлэх, хэвлэх үйл ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгжүүд нь энэ стандартад орсон таних тэмдэг, загвар санг мөрдлөг болгоно.

## 2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах баримт бичгийг эшлэл болгож ашигласан бөгөөд, өөрчлөлт орох нь энэ стандартыг шинэчлэх үндэслэл шаардлага болохгүй. Үүнд:
Байр зүйн 1:25000, 1:50000, 1:100000-ны масштабтай зургийн томьёолсон тэмдэг” - 2001 он, Улсын Геодези, зураг зүйн газар;
DGIWG Portrayal Standard for Multinational Geospatial Co-Production Program (MGCP) Data;
MGCP Feature and Attribute Catalogue TRD3 v3.0;
Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн таних тэмдгийн загвар, кодчилол - 2010 он, ГХБГЗЗГ, “Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох төсөл”.

## 3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1 Газрын харилцааны салбарын хэмжил, зураглалд түгээмэл хэрэглэгддэг мэргэжлийн нэр, томьёо тодорхойлолт болон гадаад нэршлээрээ яриа болон бичгийн хэлбэрт нэгэнт хэрэглэгдэж хэвшсэн үгийг стандартад шууд тусган хэрэглэнэ.
3.2 Тэмдэг - Байр зүйн зургийн таних тэмдэг нь өөрийн код, дүрслэгдэх хэлбэр /цэг, шугам, талбай/-ээр илэрхийлэгдэх бөгөөд бусад төрлийн тэмдэгтэй хослон хэрэглэгддэг.

## 4 Норматив шаардлага

4.1 Байр зүйн зурагт дүрслэгдэх объектууд нь ангилал, кодтой байх ба тэдгээрийг өөр өөрийн гэсэн онцлогтой Тэмдгээр дүрсэлнэ.
4.2 Элементүүдийг дүрслэхдээ бусад төрлийн Тэмдэгтэй хослуулан үзүүлэхдээ хүснэгтэд үзүүлсэн жишээ зургийг ашиглана.
4.3 Элементийг хүснэгтэд үзүүлсний дагуу дүрсэлнэ.
4.3.1 Зарим өвөрмөц тэмдгийг цэгээр хүрээлэн хязгаарыг үзүүлнэ.
4.3.2 Объектын нэр болон тайлбарт хэрэглэх бичиглэлд хүснэгт болон стандартад тавьсан шаардлагыг мөрдөнө.

## 5 Таних тэмдэгт тавих ерөнхий шаардлага

5.1 Тэмдгийн хүснэгтэд бүх төрлийн байр зүйн зурагт заавал хэрэглэх Тэмдгийг үзүүлснээс гадна тухайн зориулалтын байр зүйн зураглалд гол хэрэглэгдэх газар доорх шугам сүлжээ, усжуулалтын төхөөрөмжийн гэх мэт Тэмдгийг оруулав.
5.2 Байр зүйн зурагт Тэмдгийг хоорондоо 0.3 мм-ээс багагүй зайтай үзүүлэх ёстой. Зарим шаардлагатай объектуудыг дүрслэхийн тулд тэдгээрийг зэргэлдээ объектоос бага хэмжээгээр хөндийрүүлэн зурж болно.
5.3 Байр зүйн зураг дээр газар орны объектын байршил нь масштабын бус Тэмдгээр дор дурдсан байдлаар илэрхийлэгдэнэ. Үүнд:
5.3.1 геометрийн зөв дүрсээр илэрхийлэгдэх объектын Тэмдэг (тэгш өнцөгт, гурвалжин, тойрог, таван хошуу гэх мэт) - ***Тэмдгийн дүрсийн төв***;
5.3.2 хэд хэдэн дүрсээр Тэмдгээр илэрхийлэгдэх Тэмдэг (газрын тосны болон шатах хийн цамхаг, бунхан, сүм, цамхаг хэлбэрийн байгууламж, яндан) - ***Тэмдгийн дүрсийн доод талын төв*** тус тус байна.
5.3.3 сууриндаа тэгш өнцөгт дүрсээр илэрхийлэгдсэн объектын Тэмдэг (бензин агуулах, ШТС, салхин тээрэм гэх мэт) - ***Тэмдгийн дүрсний өнцгийн орой*;**
5.3.4 холимог дүрсээр илэрхийлэгдсэн объектын Тэмдэг (дээрээ цамхагтай нефтийн ба шатдаг хийн Тэмдэг, харуул, манааны шовгор гэх мэт) – ***Тэмдгийн дүрсийн доод талын төв****-д* тус тус тохирсон байна.
5.4 Тэмдгийн дүрсүүд нь тоон бичлэгтэй байх бөгөөд түүний хэмжээ (мм-ээр)-г Тэмдгийн баруун, зүүн буюу дээр, доор нь аль боломжтой газарт нь бичнэ. Хэрэв аль нэг Тэмдгийн дэргэд ганцхан тоо бичсэн байвал уг Тэмдгийн өргөн нь өндөртэйгөө адил байна. Хэрэв хоёр тоо байвал эхний тоо нь Тэмдгийн өндрийг, хоёр дахь нь өргөнийг заана. Тэмдгийн аль нэг хэсэгт тоо өгсөн бол тэр нь Тэмдгийн хэсгийн өндөр, өргөнийг заана. Шугаман хэлбэрийн Тэмдгийн дагууд өгсөн тоо нь уг хэсгийн урт буюу хэрчим хоорондох уртыг илэрхийлнэ. Тойрог хэлбэртэй Тэмдгийн хэмжээ нь - түүний диаметр, таван хошуу хэлбэртэй нь – татагдах тойргийн диаметр, адил талт гурвалжин нь - гурвалжны өндрийн хэмжээгээр тус тус илэрхийлэгдэнэ. Хүснэгтэд хэмжээ нь өгөгдөөгүй тохиолдолд тэмдгийн хэмжээг энэ стандартад зурагдсан дүрсийн хэмжээг жишиг болгож авна.
5.5 Тэмдгийн хүснэгтийн зургууд нь тэдгээрийн хэмжээг мм-ээр илэрхийлсэн тоотой байна. Хэрэв тоо хоёр байвал эхнийх нь Тэмдгийн өндрийг, хоёр дахь нь түүний өргөнийг илэрхийлнэ. Мөн зургийн хажууд нэг тоо өгөгдсөн бол өндөр, өргөн нь адил харин тоо өгөгдөөгүй бол Тэмдгийн хэмжээг хүснэгтийн зургаар тодорхойлно.
5.6 Бүх Тэмдгийн хэмжээ нь дундаж ачаалалтай байр зүйн зургийн жишгээр зохиогдсон болно. Онцгой тохиолдолд зургийн агуулга, ачааллыг харгалзан Тэмдгийн хэмжээг ихэсгэж, багасгаж болно.
5.7 Төмөр зам, зам дагуу гэрэлтүүлгийн шон зэргийг явж буй чиглэлийн дагуу тэнхлэгээр нь зураглана. Хашаа, хайсны эргэлт доголыг гадна талаас нь зураглана.
5.8 Талбай, ургамал, хөдөө аж ахуйн эдэлбэр газар, газрын гадаргын бичил тогтоц, намаг, хужир, марз, хөрс зэргийг үзүүлэх Тэмдэг хоорондын хүснэгтэд заасан зайг цэглэн хүрээлэх хэмжээг нь 25 см.кв болон түүнээс их бол 1.5 эсвэл 3 дахин ихэсгэж болно.
5.9 Энэхүү дунд масштабын зурагт байр зүйн объектууд нь хүснэгтэд ижил нэг Тэмдэгтэй (цооног, радио цамхаг, эргийн шугам, хүрхрээ, газрын эвдрэл, ургамал, задгай газар гэх мэт) байвал тайлбар бичиглэлийн хэмжээ нь хүснэгтэд үзүүлсэн загвар бичиглэлтэй ижил байна.
5.10 Тодорхой салбарын хэрэгцээнд зориулагдсан байр зүйн зургийг эх хувиас нь захиалагчийн тогтоосон байдлаар (тусгай зориулалтын) бэлтгэн гүйцэтгэнэ.

## 6 Таних тэмдгийн бичиглэлд тавих шаардлага

6.1 Бүх төрлийн байр зүйн зурагт цагаан толгойн үсэг, мөрөөр бичих үсгүүд, 10 хүртэлх тоон бичиглэл зэргийг ашиглана.

6.2 Байр зүйн зурагт товчилсон үгийн ард цэг тавина. Хэд хэдэн үгийг товчилсон бол хоорондх нь цэгээр хязгаарлаж зай авахгүй бичнэ.

6.3. Зургийн тайлбар бичиглэл "Arial", "Times New Roman" үсгийн 4.3-24 мм өндөртэй фонтоор бичнэ.

6.4 Байр зүйн зургийн чанарыг хангах, олшруулах болон багасгах, өсгөн томруулахад зориулан бичиглэлийн өндөр, өргөнийг өгөгдсөн хэмжээний 1/3-аар ихэсгэх буюу багасгаж болно. Энэ зарчмыг хамгийн их буюу хамгийн бага ачааллалтай байр зүйн зурагт хэрэглэнэ.

6.5 Суурин газрын нэрийг зураглагдсан газрын баруун гар талд бичнэ. Хэрэв хот, суурин газрын талбай тухайн нэрэлбэр зургийн ихэнх хэсгийг эзэлж байвал тэдгээрийн нэрийг 1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн хойд хүрээнд байрлуулна.

6.6 Байр зүйн зурагт зураглах хот, суурин газрын нэрийг зөвхөн нэг хэмжээний бичиглэлээр өгнө. Хөдөөгийн суурин, зуслан зэрэгт тэдгээрийн оршин суугчдын тоог харгалзан 4 хэмжээний бичиглэлийг хэрэглэж болно. Үүнийг үйлдвэрийн газар, төмөр замын буудал, усан зогсоол зэргийн нэрийг байр зүйн зурагт байрлуулахад түгээмэл хэрэглэдэг. Хот, суурин газрын нэр болон бусад объектын хоёр дахь бичиглэлийн нэрийг хашилтад өгч үндсэн нэрийн дор бичнэ.

6.7 Гол, горхи, ганга жалга, суваг шуудуу зэрэг үргэлжилсэн байгууламжийн нэрийг тэдгээрийн дүрслэл дагуу бичиж байрлуулна. Усан тогтоц, арал, хясаа, газрын өндөр нам, намаг, өвөрмөц газар зэргийн нэрийг бүтнээр нь буюу хураангуйлсан байдлаар бичнэ. Тухайлбал: "Холбоо нуур", "Холб.н.", "Хэрлэн арал", "Хэрл. а." гэх мэт.

6.8 Уул нуруу, говь цөл гэх мэт асар уудам талбай эзэлсэн байгалийн объектуудын нэрийг дунд масштабын байр зүйн зурагт байршлын дагуу бичнэ.

6.9 Тэмдгийн тайлбар бичиглэл нь тэдгээрийн үндсэн хэсэг бөгөөд байр зүйн зургийн объектуудыг зураглахад зайлшгүй мөрдөгдөнө. Тайлбар бичиглэлийг зураглагдсан объектын зүүн талд босоо байрлалаар бусад Тэмдэг багатай, зай бүхий газар бичиж байрлуулна. Байр зүйн зурагт тайлбар бичиглэл хийх зайнаас хамааран тайлбар бичиглэлийг бүтнээр буюу хураангуйлсан байдлаар өгнө. Үүнд хоёр хувилбар байдаг. Тухайлбал: "Хэрлэн" (тогтоосон нэр) "Хэр." эсвэл "Х", "Модны" (тайлбар) " Мод." эсвэл "М" гэх мэт

6.10 Байр зүйн зурагт хэрэглэгдэх хураангуйлсан үгийг "Хураангуйлсан үгийн жагсаалт"-ын дагуу хэрэглэнэ. "Хураангуйлсан үгийн жагсаалт"-д ороогүй ямар нэг нэрийг тодорхой болгох зориулалтаар нэмж хэрэглэж болно. Харин хураангуйлсан үг нь 3-аас доошгүй үсэгтэй байна.

6.11 Байр зүйн зургийн хүрээний хойд ба доод хэсэгт бичигдэх бичиглэл, үндсэн бичиглэл байна. Зургийн хүрээний баруун, зүүн талд бичиглэл хийхгүй.

6.12 Хэрэв ажлын даалгаварт заавал мөрдөгдөх бичиглэлээс гадна нэмэлт Тэмдэг ба хураангуйлсан үг хэрэглэх бол байр зүйн зургийн хүрээний зүүн талд зурж үзүүлэх ба үгийг бүтнээр бичнэ.

6.13 Байр зүйн зургийн масштаб, байр зүйн зураглалын талбайтай уялдуулан стандарт нэрэлбэр буюу дугаарыг өгнө.

# 7 Таних тэмдэг

| д/д | код | Газрын гадаргын элементийн нэр | Дүрслэх хэлбэр | Масштаб 1:25 000, 1:50 000, 1:100 000 | |
|---|---|---|---|---|---|
| | | **Геодезийн цэг тэмдэгт** | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 1 | G101_P | Одон орны цэг | цэг | ★ 2.1 | ★ 1.6 |
| 2 | G102_P | GPS-ийн байнгын ажиллагаатай станц | цэг | 2.4 2.2 | 2.0 1.6 |
| 3 | G104_P | Триангуляцийн сүлжээний цэг | цэг | 0.2 1.8 | 0.15 1.4 |
| 4 | G107_P | Өндрийн сүлжээний цэг | цэг | 1.2 | 0.9 |
| 5 | G101_T | Цэг тэмдэгтийн дугаар, өндөр | үсэг | *777.9* | *777.9* |
| | | **Авто зам** | | 1:25 000 | 1:50 000-1:100 000 |
| 6 | A101_L | Хурдны зам | шугам | 0.30 0.15 0.30 1.6 | 0.2 0.12 0.2 1.4 |
| 7 | A102_L | Засмал зам | шугам | 0.25 0.70 0.25 1.2 | 0.2 0.6 0.2 1.0 |
| 8 | A103_L | Сайжруулсан зам | шугам | 0.15 0.50 0.15 0.8 | 0.1 0.4 0.1 0.6 |
| 9 | A104_L | Хөрсөн зам | шугам | 0.3 0.2 1.0 4.0 | |
| 10 | A106_L | Жим | шугам | 0.2 1.0 2.5 | 2.0 1.0 |
| 11 | A102_T | Авто замын дугаар, үзүүлэлт | үсэг | *8(12)Б* | |
| | | **Зам түүний байгууламж** | | 1:25 000 | 1:50 000-1:100 000 |
| 12 | A204_L | Гүүр | шугам | | - |
| 13 | A204_P | Гүүр | цэг | | |
| 14 | A212_L | Ус зайлуулах хоолой | шугам | 1.0 0.5 0.15 | 1.0 0.5 0.12 |
| 15 | A202_T | Замын байгууламжийн тайлбар бичиглэл | үсэг | *Т. М. ТБ.* | *Ч.* |
| 16 | A205_T | Замын байгууламжийн үзүүлэлт | үсэг | 3-5 / 6 | |
| | | **Замын элемент** | | 1:25 000 | 1:50 000-1:100 000 |
| 17 | A304_P | Авто зогсоолын тэмдэг | цэг | 1.5 1.5 | |
| 18 | A308_P | Замын тэмдэг | цэг | 1.0 2.5 | |
| 19 | A310_T | Замын км-ийн тэмдэг | тоо | *720* | *720* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | A311_L | Хурд саарулагч | шугам | 0.15 | 0.12 |
| | | **Төмөр зам** | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 21 | A401_L | Төмөр зам | шугам | 0.5 | 0.15 |
| 22 | A401_T | Төмөр замын тайлбар бичиглэл | үсэг | *нар.* | *нар.* |
| | **Барилга** | | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 23 | B101_A | Энгийн байр, орон сууц | талбай | | |
| 24 | B102_A | Орон сууцны бус барилга | талбай | | |
| 25 | B103_P | Барилга /масштабын бус/ | цэг | 0.4 0.6 0.6 0.9 0.8 1.2 | 0.4 0.6 0.5 0.8 0.6 1.0 |
| 26 | B117_A | Хороолол, хотхон | талбай | *0.12* *0.12* | - |
| 27 | B119_P | Гэр /хаваржаа, өвөлжөө/ | цэг | 1.0 1.8 | 0.8 1.4 |
| 28 | B102_T | Барилга, байгууламжийн тайлбар бичиглэл | үсэг | *барь. нур. зоорь. барим. хөш.* | *барь. хүл. ЗЦХ.* |
| | **Олон нийтийн байгууллага** | | | | |
| 29 | B201_P | Нийслэл хотын захиргаа | цэг | *1.8* | |
| 30 | B202_P | Хот, Аймгийн захиргаа | цэг | *1.8* | |
| 31 | B203_P | Сум, Дүүргийн захиргаа | цэг | *1.8* | |
| 32 | B204_P | Баг, Хорооны байр | цэг | *1.8* | |
| | **Соёл, боловсролын байгууллага** | | | | |
| 33 | B307_P | Буддын хийд | цэг | 2.2 2.0 | |
| 34 | B321_P | Хөшөө баримал | цэг | 2.0 1.2 | |
| | **Үйлчилгээний байгууллага** | | | | |
| 35 | B407_P | Галт тэрэгний буудал, өртөө | цэг | *1.2* | |
| 36 | B409_P | Нисэх онгоцны буудал | цэг | *2.4* | |
| 37 | B410_P | Шатахуун түгээгүүр | цэг | *1.5* | |
| | **Үйлдвэр, худалдаа** | | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 38 | B501_P | Үйлдвэр | цэг | 1.6 0.5 | 1.2 0.4 |
| 39 | B502_P | Цахилгаан станц | цэг | d *2.5* | d *2.0* |
| 40 | B503_P | Дэд станц /ТП, РП/ | цэг | 2.4 1.0 | 2.0 0.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Хашаа** | | | |
| 41 | B701_L | Банз буюу модон хашаа | шугам | 1.5 0.2 0.15 0.4 | |
| 42 | B702_L | Бетон чулуун хашаа | шугам | 0.3 0.4 0.15 4.0 | |
| 43 | B703_L | Төмөр хашаа | шугам | 2.5 0.6 0.5 0.15 | |
| 44 | B704_L | Төмөр торон хашаа | шугам | 0.4 0.15 2.5 | |
| 45 | B705_L | Жижиг хашаа /хайс/ | шугам | 0.4 0.15 2.5 | |
| 46 | B706_P | Малын хашаа | цэг | 1.2 | 1.0 |
| | | **Аж үйлдвэрийн байгууламж** | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 47 | C101_A | Объект, элементийн хил | талбай | 0.2 | |
| 48 | C103_P | Уурхайн амсар | цэг | 1.8 | 1.4 |
| 49 | C105_P | Хаагдсан уурхай, орд газар | цэг | 1.8 | 1.4 |
| 50 | C101_T | Аж үйлдвэрийн байгууламжийн тайлбар бичиглэл | үсэг | *янд. газ.тос. геол.* | *ган. хүчил. цоон.* |
| | | **Цахилгаан, холбооны байгууламж** | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 51 | C203_L | Цахилгаан дамжуулах шугам /өндөр хүчдэл/ | шугам | 0.8 0.4 0.15 8.0 8.0 | |
| 52 | C204_L | Цахилгаан дамжуулах шугам /нам хүчдэл/ | шугам | 0.4 0.15 6.0 10.0 | |
| 53 | C206_L | Цахилгаан дамжуулах шугам /газар доорх, өндөр хүчдэл/ | шугам | 0.15 8.0 2.0 | |
| 54 | C207_L | Цахилгаан дамжуулах шугам /газар доорх, нам хүчдэл/ | шугам | 0.4 0.15 6.0 2.0 | |
| 55 | C207_L | Холбооны шугам /газар дээрх/ | шугам | 0.4 0.15 5.0 | |
| 56 | C209_L | Холбооны шугам /газар доорх/ | шугам | 0.4 0.15 5.0 1.5 | |
| 57 | C210_L | Шилэн кабель /газар дээрх/ | шугам | 0.15 | |
| 58 | C210_L | Шилэн кабель /газар доорх/ | шугам | 0.15 5.0 1.5 | |
| 59 | C211_P | Телевиз, радиогийн цамхаг /антен/ | цэг | 2.0 2.6 | 1.5 2.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 60 | C212_P | Үүрэн холбооны антен | цэг | 2.6 1.5 | 2.0 1.2 |
| 61 | C214_P | Салхин сэнс | цэг | 2.6 1.3 | 2.0 1.1 |
| 62 | C215_P | Нарны зай хураагуур | цэг | 2.0 2.0 1.0 | |
| 63 | C200_T | Цахилгаан, холбооны байгууламжийн тайлбар бичиглэл | үсэг | 2ЦДШ | |
| 64 | C201_T | Цахилгаан, холбооны байгууламжийн үзүүлэлт | үсэг | *110кв* | |
| | **Ус, цаг уур** | | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 65 | C401_P | Салхины хурд, чиглэл заагч | цэг | 1.3 2.0 | 1.0 1.6 |
| 66 | C400_T | Ус, цаг уурын элементийн тайлбар бичиглэл | үсэг | *ус.цаг.уур* | *ус.цаг.уур* |
| | **Ус зүй** | | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 67 | E101_A | Гол | талбай |  | |
| 68 | E101_L | Гол /нарийн/ | шугам |  | |
| 69 | E102_A | Ширгэдэг гол | талбай |  | |
| 70 | E102_L | Ширгэдэг гол /нарийн/ | шугам |  | |
| 71 | E103_A | Нуур | талбай |  | |
| 72 | E104_A | Нуур /ширгэдэг/ | талбай |  | |
| 73 | E106_P | Усны түвшний тоот | цэг | 1.0 | 0.8 |
| 74 | E108_L | Урсгал усны чиглэл | шугам | 0.2 | |
| 75 | E109_P | Булаг, шанд | цэг | 1.0 *бул.* | 0.8 *бул.* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 76 | E110_P | Рашаан | цэг | 1.2 *раш.* | 1.0 |
| 77 | E111_A | Намаг /гаталдаггүй/ | талбай | | |
| 78 | E112_A | Намаг /гаталдаг/ | талбай | | |
| 79 | E114_A | Марз /гаталдаггүй/ | талбай | | |
| 80 | E115_A | Марз /гаталдаг/ | талбай | | |
| 81 | E116_L | Хүрхрээ | шугам | хурх. 5 | хурх. 5 |
| 82 | E101_T | Гол, нуур, булгийн нэр | үсэг | *нуур. давст. бул. ус.сан* | *борс.* |
| 83 | E106_T | Гол, усны бичиглэлт, үзүүлэлт | үсэг | *1115.7/8.X 2.4 Ч III-VI* | *1100.9 1.2/0.9 Э бохир. бет.* |
| 84 | E108_T | Усны урсгалын хурд | тоо | *0.5* | *0.2* |
| | | **Усны байгууламж** | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 85 | E201_P | Худаг /гар, ховоотой/ | цэг | 1.4 | 1.1 |
| 86 | E202_P | Худаг /мотортой/ | цэг | 0.3 1.2 2.0 | |
| 87 | E203_P | Худаг /эргүүлдэг/ | цэг | 2.0 1.0 | |
| 88 | E204_P | Худаг /дүүжинтэй/ | цэг | 1.4 3.3 | 1.1 3.0 |
| 89 | E207_L | Гатлага | шугам | ол. 1.2-450/Э-0.5 хөв. дамн. 1.0 2.0 | ол. хөв. дамн. 0.8 1.0 |
| 90 | E208_L | Гарам, олом | шугам | | |
| 91 | E214_P | Усан онгоцны зогсоол | цэг | 2.5 2.0 | 2.0 1.6 |
| 92 | E201_T | Худгийн нэр | үсэг | Сайн усны худаг Х. бул. | |
| 93 | E202_T | Худгийн үзүүлэлт | тоо | *500л/ц* | |
| 94 | E206_T | Усны байгууламжийн тайлбар | үсэг | *ган. бет. чул.* | |
| 95 | E208_T | Олом, гармын үзүүлэлт | тоо | ол. 1.2-450/Э-0.5 | |
| | | **Мөнх цас, мөсөн гол** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 96 | E301_L | Мөсөн гол /Тодруулсан шугам/ | шугам | 0.2 | |
| 97 | E302_L | Мөсөн гол /Үндсэн шугам/ | шугам | 0.1-0.12 | |
| 98 | E303_L | Мөсөн гол, хөр цасны хүрээ | шугам | 0.3 1.0 | |
| 99 | E305_P | Мөсөн худаг | цэг | 1.8 | |
| 100 | E306_A | Хөр цас, хунгар | талбай | | |
| 101 | E306_T | Мөнх цас, мөсөн голын бичиглэл | үсэг | *дошин.* | |
| | **Газрын гадарга** | | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 102 | F101_L | Хаялбарын шугам (Тодруулсан шугам) | шугам | 0.2 | |
| 103 | F102_L | Хаялбарын шугам (Үндсэн шугам) | шугам | 0.1-0.12 | |
| 104 | F103_L | Хаялбарын шугам (Нэмэлт шугам) | шугам | 0.1-0.12 5.0 1.0 | 0.1-0.12 3.8 0.8 |
| 105 | F104_L | Хаялбарын шугам (Туслах шугам) | шугам | 0.12-0.15 2.0 1.0 | 0.1-0.12 0.6 0.6 |
| 106 | F105_L | Ус хагалбарын шугам | шугам | 0.6 | |
| 107 | F106_P | Өндрийн цэг | цэг | 0.6 *347.1* 0.5 *1338.6* | |
| 108 | F107_L | Жалга | шугам | 0.15 | |
| 109 | F108_A | Сайр | талбай | | |
| 110 | F108_L | Сайр | шугам | 2.0 0.5 | |
| 111 | F109_P | Даваа | цэг | 2.6 2.0 2.0 1.5 | 2.0 1.5 1.5 1.2 |
| 112 | F111_L | Эрэг, ганга, гуу | шугам | 0.15 1.0 1.0 | |
| 113 | F112_L | Ханан хад | шугам | | |
| 114 | F113_P | Үлдэц цохио | цэг | 2.0 1.5 | 1.5 1.1 |
| 115 | F114_P | Нүх | цэг | 0.8 2.0 | 1.5 |
| 116 | F115_P | Дов /хаялбараар дүрслэгдэхгүй/ | цэг | 1.5 | 1.2 |
| 117 | F116_P | Агуй нүхний амсар | цэг | 1.2 2.4 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 118 | F117_P | Сондгой хад | цэг | 1.2 1.5 | 1.0 1.2 |
| 119 | F118_L | Сэврэй хад | шугам | 3.6 | 1.0 |
| 120 | F119_L | Галт уулын тогоо | шугам | *Галт уул* | *Галт уул* |
| 121 | F122_L | Хөмөг | шугам | | |
| 122 | F123_L | Мөргөцөг | шугам | | |
| 123 | F101_T | Хаялбарын тоо | тоо | 1200 | |
| 124 | F106_T | Өндрийн тоо | тоо | 5043.0 3525.2 | |
| 125 | F107_T | Даваа, жалга, сайрын нэр | үсэг | *Солонготын даваа* | *Айдасын даваа* |
| 126 | F110_T | Жалга, сайр, эрэг, нух, довын үзүүлэлт | тоо | *3.5* | *1.3* |
| 127 | F113_T | Даваа, үлдэц цохио, хадны үзүүлэлт | тоо | *4338.2* *V-IX* 3.2 | *2354.5* *5.1* |
| | **Хөрс, газрын бичил гадарга** | | | 1:25 000 | 1:50 000-1:100 000 |
| 128 | F201_A | Элс | талбай | | |
| 129 | F201_P | Элс | цэг | | |
| 130 | F203_A | Шал | талбай | | |
| 131 | F203_P | Шал | цэг | | |
| 132 | F204_A | Шаварлаг гадарга | талбай | 10.0 5.0 | - |
| 133 | F205_A | Чулуу, хайрга | талбай | | |
| 134 | F205_P | Чулуу, хайрга | цэг | | |
| 135 | F207_A | Ургаа чулуу | талбай | | |
| 136 | F208_A | Довцог гадарга | талбай | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 137 | F209_A | Дов, сондуултай гадарга | талбай | 1.1 1.4 5.0 | |
| | | **Газрын гадарга дээрх байгууламж** | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 138 | F301_A | Далан | талбай | 0.12 | |
| 139 | F301_L | Далан | шугам | 2.0 1.5 | 2.0 0.5 1.2 |
| 140 | F302_L | Далан /масштабд илэрхийлэгдэхгүй/ | шугам | 0.3 | |
| 141 | F303_L | Үерийн усны суваг, шуудуу | шугам | 0.15 | |
| 142 | F304_L | Үерийн усны суваг, шуудуу /газар доорх/ | шугам | 2.0 1.0 0.15 | |
| 143 | F305_P | Хиргисүүр | цэг | 2.0 1.0 | 1.5 0.8 |
| 144 | F306_P | Овоолго шороо, ухсан нүх | цэг | 1.8 1.8 | 1.5 1.5 |
| 145 | F307_P | Овоо | цэг | 2.0 1.0 | 1.5 0.8 |
| 146 | F308_P | Оршуулгын газар | цэг | 1.2 1.8 | 1.0 1.5 |
| 147 | F308_A | Оршуулгын газар | талбай | | |
| 148 | F309_P | Эртний дурсгалт газар (туурь) | цэг | 1.0 1.6 | 0.8 1.2 |
| 149 | F310_L | Эртний хана хэрэм | шугам | 0.6 | |
| 150 | F301_T | Далан, суваг, шуудууны үзүүлэлт | тоо | *1.5* / *0.4* *1.4* | *3.4* / *0.5* *2.6* / *1.5* |
| 151 | F307_T | Газрын гадарга дээрх байгууламжийн тайлбар бичиглэл | үсэг | *хиргис. агуй. галт уул. бет. чул.* | *агуй. дов. шав.тогоо. бет. чул.* |
| | | **Ургамал зүй** | | 1:25 000 | 1:50 000-1:100 000 |
| 152 | D101_A | Ой | талбай | | |
| 153 | D101_P | Ой | цэг | 0.6 1.1 | 0.5 0.9 |
| 154 | D102_L | Ургамлын хил | шугам | 1.0 0.2 | |
| 155 | D103_P | Ойд зонхилох мод | цэг | 2.3 1.2 2.3 1.2 | 1.8 1.0 1.8 1.0 |
| 156 | D104_P | Холимог ойн тэмдэг | цэг | 2.3 2.6 | 1.8 2.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 157 | D106_A | Зулзаган мод | талбай |  |  |
| 158 | D111_A | Зулзаган мод зонхилдог сийрэг ой | талбай |  |  |
| 159 | D112_A | Дархи | талбай |  |  |
| 160 | D113_A | Шатсан хуурайшсан ой | талбай |  |  |
| 161 | D114_A | Огтолсон ой | талбай |  |  |
| 162 | D115_P | Мод | цэг |  |  |
| 163 | D116_P | Өвс, ургамал | цэг |  |  |
| 164 | D117_A | Бут, сөөг | талбай |  |  |
| 165 | D119_A | Өргөст бут, сөөг | талбай |  |  |
| 166 | D121_A | Сөөгхөн | талбай |  |  |
| 167 | D122_A | Сөөгхөн /тачир/ | талбай |  | |
| 168 | D123_A | Нугын ургамал | талбай |  |  |
| 169 | D124_A | Сахлаг ургамал | талбай |  |  |
| 170 | D125_A | Тачир ургамал | талбай |  |  |
| 171 | D126_A | Зэгс, хулсны төрлийн ургамал | талбай |  |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 172 | D127_A | Тал хээрийн ургамал | талбай |  |  |
| 173 | D128_A | Заг /ширэнгэ/ | талбай |  |  |
| 174 | D129_A | Хөвд | талбай |  |  |
| 175 | D130_A | Хаг, хагдны төрлийн ургамал | талбай |  |  |
| 176 | D101_T | Ургамлын тайлбар бичиглэл | үсэг | *нарс. шинэс. бут.* | *нарс. хус. бут.* |
| 177 | D103_T | Модны үзүүлэлт, тайлбар | тоо | $\frac{8}{0.07}5$ | $\frac{15}{0.18}4$ |
| | | **Таримал ургамал** | | 1:25 000 | 1:50 000-1:100 000 |
| 178 | D201_A | Ногооны талбай | талбай |  | |
| 179 | D202_A | Тариан талбай | талбай |  | |
| 180 | D206_A | Мод, жимс үржүүлгийн газар | талбай |  |  |
| 181 | D208_A | Атар газар | талбай |  | |
| 185 | D201_T | Таримал ургамлын тайлбар бичиглэл | үсэг | *хус шинэс мод.урж.газ* | *алим. үржүүл.* |
| | **Засаг захиргааны хил** | | | 1:25 000-1:50 000 | 1:100 000 |
| 183 | H101_L | Улсын хил | шугам |  |  |
| 184 | H102_L | Аймаг, Нийслэлийн хил | шугам |  |  |
| 185 | H103_L | Сум, дүүргийн хил | шугам |  |  |
| 186 | H104_L | Баг, хорооны хил | шугам |  |  |
| 187 | H105_L | Тусгай хамгаалалттай газрын хил | шугам |  | |
| 188 | H101_P | Хилийн тэмдэгт | цэг | ⊙ 1.0 | |
| 189 | H101_T | Хилийн тэмдэгтийн дугаар | тоо | *999* | *999* |

# 8 Таних тэмдгийн тайлбар, түүнд тавигдах шаардлага

## 8.1 Геодезийн цэг тэмдэгт

8.1.1 Улсын геодезийн сүлжээний цэг тэмдэгт нь Засгийн газрын 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицол өндрийн нэгдсэн тогтолцоонд, ГХГЗЗГ-ын даргын 2014 он А/112 дугаар тушаалаар баталсан ITRF 2008 эринд тодорхойлсон одон орон, GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, GPS, триангуляци, полигонометр, трилатераци, гравиметр, өндрийн, зураглалын сүлжээний цэг байна. Удаан хугацаагаар ашиглагдахаар бэхэлсэн геодезийн сүлжээний цэгт төмөр бетон тэмдэгт, зам төмөр, бетондсон төмөр, яндан хоолой зэрэг багтана. Түр хугацаагаар ашиглах цэгт модон шон, гадас, бетондоогүй төмөр зэрэг орно.

8.1.2 Байр зүйн зурагт солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд тодорхойлогдсон улсын геодезийн сүлжээний бүх цэг тэмдэгт болон геодезийн өтгөрүүлэлтийн сүлжээний цэг тэмдэгт, байр зүйн зураглалын ажлын цэгүүдийг /цаашид Цэг гэх/ масштабын бус Тэмдгээр дүрслэн үзүүлнэ. Цэгийн төвийн өндрийг 0.01 м-ийн нарийвчлалтай бичнэ.

8.1.3 1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт Цэгийн дээд төв (реперийн толгой буюу маркийн төв)-ийн өндөр ба газрын өндөр хоорондох зөрөө нь 0.2 м-ээс их бол Цэгийн өндрийг хуваариар үзүүлнэ. Хүртвэрт - дээд төв (реперийн толгой, маркийн төв)-ийн өндөр, хуваарьт - газрын өндөр бичигдэнэ.

8.1.4 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

1-4 /G101_P - G107_P/. Улсын геодезийн сүлжээний Цэг тэмдэгт бүрт өндрийг бичнэ.

2 /G102_P/. Антеныхаа солбицол, өндрийг өндөр нарийвчлалтай тодорхойлсон, 24 цагийн турш олон улсын хиймэл дагуулаас өгөгдөл хүлээн авч тасралтгүй ажилладаг, 2 долгионы байрлал тодорхойлох иж бүрдлийг GNSS-ийн байнгын ажиллагаатай станц гэдэг. Уг байнгын ажиллагаатай станц нь байшин болон багана дээр бэхлэгдсэн байна.

3 /G104_P/. "Улсын геодезийн сүлжээ байгуулах тухай" 1939, 1954, 1961 онд батлагдсан зааврaар байгуулсан триангуляцийн сүлжээний Цэгийг уг давхаргад Тэмдгээр тэмдэглэнэ.

4 /G107_P/. Өндрийн сүлжээний Цэгийг суурь, энгийн (хөрсний), хадны, ханын ба түр репер гэж ангилдаг. Улсын нивелирийн сүлжээ байгуулах зааврын дагуу геометрийн нивелирдлэгээр тодорхойлсон өндөртэй улсын нивелирийн I, II, III ба IV ангийн сүлжээний Цэгүүд (репер, марк)-ийг Тэмдгээр үзүүлнэ. Түр реперийг дүрслэхгүй.

5 /G101_T/. Цэг тэмдэгтийн дугаар, өндрийг энэ давхаргад бичихдээ хуваарьт Цэгийн төвийн өндрийг, хүртвэрт Цэгийн дугаарыг бичнэ. Цэгийн төвийн өндрийг 0.01 м-ийн нарийвчлалтай бичнэ.

## 8.2 Авто зам

8.2.1 Авто замыг байр зүйн зурагт хурдны зам, засмал зам, сайжруулсан зам, хөрсөн зам, жим гэж хэд хэд ангилан дүрсэлнэ.

8.2.2 Дунд масштабын байр зүйн зурагт хучилттай болон хучилтгүй авто замыг масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ. Замыг тодорхой суурин хүртэл эсвэл аль нэг авто замтай огтлолцох хүртэл үргэлжлүүлнэ.

8.2.3 Замыг дүрслэхдээ түүний үзүүлэлтийг дор дурдсаны дагуу өгнө. Үүнд:

8.2.3.1 Дээд ангилалын авто замд автомашин нэг чиглэлд явах урсгалын өргөнийг 0.5 м хүртэл нарийвчлалтай бичиж урсгалын - тоо, хучилтын материалын нэр;

8.2.3.2 Сайжруулсан хучилттай ба хучилттай авто замд урсгал хэсгийн өргөн 0.5 м хүртэл нарийвчлалтай, замын далангийн өргөнийг хаалтад бүхэл метрээр, хучилтын материалын нэр;
8.2.3.3 Хучилтгүй замд урсгалын хэсгийн өргөнийг бүхэл метрээр;
8.2.4 Замын хучилтын материалыг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэнэ:
А - асфальт, бетон асфальт, М - мод, банз, Ч - нунтагласан чулуу, Ц – цемент, Х – хайрга, Б - битум гэх мэт.
8.2.5 Гол, мөрөн, нуур, далай, намгийг хөлдсөн үед явж болох замуудыг байр зүйн зурагт "*өвл.*" гэсэн тайлбар бичиглэлтэй үзүүлнэ.
8.2.6 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

6-7 /A101_L - A102_L/. Хурдны замын Тэмдгээр авто машин дээд зэргийн хурдтай (7000 авт/хоног) хөдлөх гол замыг дүрслэхэд хэрэглэнэ. Ийм зам нь техникийн түвшин, хангамжаар I ангилалд хамаарах бөгөөд хоёр урсгалтай, тус бүр нь 7.5 м-ээс багагүй өргөн, асфальтан бетон, цемент зэрэг хучилттай, зам хоорондох тусгаарлах бүсийн өргөн нь 5 м-ээс багагүй, дагуугийн налуу нь 30%-аас ихгүй төмөр зам ба авто замтай огтлолцох хэсэг нь янз бүрийн түвшинд байна.

Авто тээврийн засмал замын Тэмдгийг авто машины хөдөлгөөн ихтэй (1500-7000 авто/хоног хүртэл) замд хэрэглэх бөгөөд ийм замын урсгалын хэсэг нь 7 м-ээс багагүй өргөнтэй, хатуу суурьтай байна.

8 /A103_L/. Сайжруулсан авто зам гол замаас /хурдны, засмал/ бага өргөнтэйгөөрөө ялгагдах боловч хөнгөн хучилттай (хайрга, хайрганцар гэх мэт) байж болно. Энэ зам нь байнга засаж сэлбэгдэж байдаг, хатуу суурьгүй, урсгалын хэсэг нь 4-6 м-ээс багагүй өргөнтэй байна.

9 /A104_L/. Хөрсөн замд аймаг, сум, баг, суурин, зуслан болон бусад төвлөрсөн газарт хүрэх хучилтгүй замууд болон элс, элсэн цөл, уул, ой, хөвчийн ердийн авто хөсгийн замууд багтана. Хучилтгүй (хөрсөн зам) авто замын Тэмдгээр хот, суурин хооронд зорчих баталгаажсан замыг үргэлжилсэн шугамаар үзүүлнэ. Хээрийн болон ой доторх замыг тасархай зураасаар үзүүлнэ. Хэрэв дунд масштабын байр зүйн зурагт хөрсөн замыг хээрийн, ойн гэж ангилах бол "ойн зам", "хээр.зам" гэсэн тайлбар хийнэ. Хэрэв хөрсөн зам далан дээгүүр явбал түүнийг 1:25 000, 1:50 000-ны байр зүйн зурагт дүрсэлнэ.

Замын бартаат (намагтай, элстэй гэх мэт) хэсгийг тасархай зураасаар үзүүлнэ. Ийм замын дүрслэл дээр замын өргөнийг м-ээр бичнэ.

Улирлын чанартай ашигладаг замыг (хөлдсөн намаг, нуур, гол дээрх) тасархай зураасаар дүрслэх бөгөөд дэргэд нь "*өвлийн*" гэж бичнэ. Өвлийн замын дагууд 10-15 см тутамд "*өвлийн*" гэсэн үг бичнэ.

10 /A106_L/. Байр зүйн зурагт ердийн хөсгийн болон явган зөрөг жимийг адил үзүүлэх боловч ердийн хөсгийн зөрөгт тайлбар хийнэ. Ердийн хөсгийн зөрөг авто тээвэрт ашиглагдахгүй боловч говь цөлийн зарим бүсэд ийм замыг авто тээвэрт ашиглаж болдог. Хүйтэн бүс (тайга) нутагт зарим зөргийг ердийн хөсгийн тээвэрт ашиглахаас гадна чаргаар тээвэр хийхэд ашиглана. Энэ Тэмдгийг элс, элсэн цөл, уул, ой, хөвчийн ердийн хөсөг явах замд хэрэглэнэ. Эдгээр замаар зарим тохиолдолд авто хөсөг явах боломжтой бол түүний дүрслэлийн дагуу "*авто машин цагт 30 км хүртэл хурдтай явах бололцоотой*" гэх мэт тодорхойлолт өгч болно.

11 /A102_T/. Авто замын дугаар, индексийг байр зүйн зурагт 15-20 см зайтай тэмдэглэнэ. Хэрэв зам нь дугаараас гадна үсгэн Тэмдэгтэй бол хоёуланд нь бичнэ.

Замын үсгэн индексийг оруулахад дараах зэрэглэлийг баримтална:
"ОУЗ" – олон улсын зам,
"УЧЗ" - улсын чанартай зам,

"ОНЗ" – орон нутгийн зам.
А - асфальт, Б - бетон, Ч - чулуу, Х - хайрга. Эдгээр индексүүдийг авто замын тэнхлэгийн дагуу бичнэ.

Замын нийт өргөн, урсгалын өргөн дунд масштабтай байр зүйн зурагт тоон утгаар (жишээ нь: 4.2 (4.2) А) өгөгдөнө.

**8.3 Зам түүний байгууламж**

8.3.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

12-13 /A204_L - A204_P/. Авто болон төмөр зам дээгүүрх явган хүн зорчих гүүрийг масштабын бус Тэмдгээр дүрслэн материалаар нь ангилж өгнө.

Гүүрний гулдангийн материалыг бүх төрлийн масштабтай байр зүйн зурагт төмөр, төмөр бетон, модон гэж ангилан байр зүйн зурагт үсгээр "ТБ", "Т", "Ч" гэх мэтээр үзүүлнэ.

Бага хэмжээний бартаа болон хоолой дээрх гүүрний Тэмдгийг өргөн нь 3 мм-ээс бага бартаа, саад, суваг, гол дээрх гүүр болон авто зам, төмөр замын доорх ус зайлуулагч хоолой дээгүүрх гүүрийг тэмдэглэхэд хэрэглэнэ.

Гүүрийн янз бүрийн Тэмдгийг гүүрийн байгууламжийн хэмжээ, бүтцээс хамааруулж хэрэглэнэ. Гүүр нь өргөдөг, салдаг байдаг. Хөвдөг болон бусад гүүрийг зохих Тэмдгээр дүрслэн "*хөвдөг*", "*дүүжин*" гэх мэт тайлбар өгнө.

14 /A212_L/. Шуудуу, суваг, гол нь хоолойгоор дамжиж байгаа бол хоолойг тасархай хар шугамаар, байрлалаар нь үзүүлнэ. Хоолойн материалыг хүснэгтэн мэдээлэлд оруулж өгнө.

15-16 /A202_T, A205_T/. Дунд масштабын байр зүйн зурагт бүх төрлийн замын гүүрийн үзүүлэлтэд түүний урт, өргөн, даацыг үзүүлнэ. Авто зам, төмөр замын 3 м-ээс урт гүүрийн Тэмдэгтэд түүний үзүүлэлтийг бичнэ: үсгээр - гүүрийн материал (мод, төмөр бетон, чулуу, төмөр), тоогоор - хүртвэрт гүүрийн урт (эргийн тулгуурыг оролцуулан) ба өргөн (м), хуваарьт гүүрийн даац (авто машин тогтоосон даац, тонн). Хэрэв гүүрийн даац 100 тн-оос их бол "*100-аас их*" гэж бичнэ.

**8.4 Замын элемент**

8.4.1 Замын элементүүдийг сэдэвчилсэн болон мэдээллийн сан үүсгэх зориулалттай байр зүйн зурагт эсвэл ажлын даалгаварт тусгагдсан бол зураглана.
8.4.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

17-18 /A304_P, A308_P/. Авто замын дагуух тээврийн хэрэгслийн авто зогсоолын Тэмдгийг 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр ихэвчлэн хэрэглэнэ.

19 /A310_T/. Зам, түүний элементэд түүний дагуу байрлуулсан километрийн болон бусад /заах, хориглох, анхааруулах/ тэмдэг багтана. Километрийн Тэмдгийг (шон ба чулуу) орон нутгийн замд хэрэглэнэ. Уг Тэмдгийг замын аль талд байгаагаар байрлуулна. Энэ Тэмдгийг тусгайлан сэдэвчилсэн /авто замын/ зураг зохиоход заавал үзүүлнэ.

20 /A311_L/. Авто замын аваар осол, аюулгүй байдлын үүднээс байгуулсан хурд сааруулагчийг байрлалаар нь зурна.

**8.5 Төмөр зам**

8.5.1 Бүх төрлийн өргөн ба нарийн төмөр замыг байр зүйн зурагт масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ.

8.5.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

21 /A401_L/. Өргөн төмөр зам нь 1524 мм өргөнтэй, зарим оронд 1435 мм байдаг. Нарийн төмөр замыг (600-1067 мм) байр зүйн зурагт "нарийн" гэсэн тайлбар бичиглэлтэй дүрсэлнэ.

Масштабд илэрхийлэх төмөр замын аль нэг үндсэн замыг 0.5 мм, бусад замыг 0.15 мм өргөнтэй зураасаар тэмдэглэнэ. Хэрэв бүх замыг 0.3 мм-ийн хуваарьтай зураасаар дүрслэх боломжгүй бол шугамыг замын тоогоор бус ерөнхий хэлбэр тогтцыг хадгалахаар бодож үзүүлнэ. Ийм байдлаар үйлдвэр бусад байгууламж дахь төмөр замыг дүрсэлнэ.

22 /A401_T/. Төмөр замын өргөн, нарийн, ажилладаггүй гэх зэрэг тайлбар бичиглэлийг масштаб тус бүрт тохирсон хэмжээгээр уг давхаргад бичиж өгнө.

**8.6 Барилга, байгууламж**

8.6.1 Барилга, байгууламж гэдэгт - бага оврын байшин, хөнгөн хийцийн дээвэртэй барилга, өөрийн хэмжээ, зориулалтаараа орон сууц, албан ба үйлдвэрийн зориулалттай барилга багтана.

8.6.2 Байр зүйн зурагт барилга, байгууламжийг дотор нь: орон сууцны, орон сууцны бус гэж ангилж зурна.

8.6.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

23-25 /B101_A – B103_P/. Хот, суурин газар, түүний захад орших барилга, орон сууцыг дотор талыг нь хар саарал өнгөөр будсан гурван янзын хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэрийн Тэмдгээр дүрсэлнэ. Хамгийн бага хэмжээтэй Тэмдгээр хот, суурин газрын барилга байгууламжийг; дунд хэмжээний Тэмдгээр хот, суурин газрын захад байгаа эсвэл хороолол доторх шигүү байрлалтай барилга байгууламжаас онцгойлон дүрслэх барилга, байгууламжийг; бага хэмжээний Тэмдгээр хот, суурин газраас алслагдсан, чиг баримжаа болж чадахуйц барилга байгууламжийг тус тус дүрсэлнэ. Тэмдгийг байрлуулахдаа уг барилга байгууламжийн газар дээрх чигийн дагуу оруулна.

Байр зүйн зурагт өөрийн хэмжээгээр илэрхийлэгдэх барилга байгууламжийг түүний жинхэнэ хэмжээгээр сууриар нь үзүүлнэ. Зарим онцгой байгууламжийн өндөр нь 50 м бол өндрийг бичнэ. 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт барилга, байгууламжийн хорооллыг дэвсгэр өнгөөр дүрсэлнэ.

Зургийн масштабд 0.3 мм, түүнээс өргөнөөр илэрхийлэгдэх барилга хоорондох зай талбайг (шаардлагатай үед үүнээс бага хэмжээтэй) үзүүлнэ.

1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт ийм хорооллын барилгыг дүрслэхдээ байшин хоорондын зай, завсрыг хадгалж, хороолол доторх барилгажаагүй хэсгийг ялгаж үзүүлнэ.

Энэ Тэмдгээр 1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт хоорондоо 1 ба 2 мм-ээс их (газар дээрээ 50 м-ээс их зайтай) хэмжээтэй нэг эгнээнд сийрэгдүү байрласан суурин газрын төвийг дүрсэлнэ. 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт эдгээр байшинг барилга байгууламжийн Тэмдгээр дүрсэлнэ.

1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт хөдөө орон нутгийн суурин газрын эгнээгээр байрласан барилгыг үзүүлэхдээ зургийн ачааллыг алдагдуулахгүйн тулд сондгой барилгын Тэмдгийг 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн Тэмдгийн хэмжээгээр авна.

1:25 000-ны масштабтай байр зүйн зураг дээр шигүү барилгажилттай хорооллын бүх барилгыг дэвсгэр өнгөөр ялгана.

Томоохон хотын шигүү барилгажилттай хорооллыг 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт дүрслэхдээ барилга байгууламжуудыг нэг бүрчлэн үзүүлэхгүй. 1:50 000 - 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр зөвхөн чиг баримжаа болж чадахуйц барилга, байгууламжийг үзүүлнэ.

Томоохон хотын харьяалалд 20 000-аас их хүн амтай хотууд болон барилгажилтын төрх, талбайгаар ойролцоо хотуудыг хамруулна.

Багавтар хотын шигүү барилгажилттай хороололд (20 000-аас бага хүн амтай) суурин газрын хорооллуудыг 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт үзүүлэхдээ 1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт хэрхэн дүрслэх аргыг хэрэгжүүлнэ. 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт эдгээр хот, суурин газрын барилгажилтыг дүрслэхдээ (1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зураг дээр дэвсгэр өнгөөр ялган шигүү барилгажилттай хорооллоор дүрсэлсэн бол) нэлэнхийд нь хар саарал өнгөөр будна. Энэ тохиолдолд хороолол доторх барилгажаагүй хэсэг, гудамж замын хэсгүүдийг үзүүлэх хэрэгтэй. Хар саарлаар будсан дүрсийн хамгийн бага хэмжээ нь 0.5*0.5 мм, барилгажаагүй хэсэгт 0.3*0.3 мм байна.

Хороолол маягийн буюу нэг эгнээнд байрласан барилгажилттай хорооллын (эгнээ) хэсгийг 1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт 1.4-1.5 мм, 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт 1.1-1.2 мм өргөнтэй зурвасаар тус тус дүрсэлнэ. Хэрэв барилгажилтын зурвасын өргөн нь тухайн масштабын байр зүйн зурагт дээрх хэмжээнээс их бол түүнийг масштабаар нь дүрсэлнэ.

Гудамж дагуух шигүү барилгатай хэсэгт эхний ээлжид гудамжны өнцөгт байгаа барилгууд, болон нийгэм ахуйн зэрэг томоохон барилгуудыг, дараа нь Тэмдэг хооронд 0.3 мм-ээс бага зайнд дүрслэгдэж болох бусад барилгуудыг оруулна.

Гудамжийг дүрсэлж харуулсан зурвасын өргөн буюу барилга хоорондын зай нь 5 мм-ээс ихгүй байх ёстой.

Соёл амралтын ба бусад цэцэрлэг, төгөл талбай нь 1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт 1.5x2.0 мм-ээс багагүй хэмжээтэй бол ялгаж үзүүлнэ. 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт цэцэрлэг болон сул чөлөөтэй талбайн хэмжээ нь 3.0 x 3.0 мм ба түүнээс их бол дэвсгэр өнгөөр ялгаж зурна. Харин барилгажсан хэсгийг хар саарал өнгөөр будсан бол 0.3 x 0.3 мм-ээс бага талбайтай модлог ургамлыг дүрслэхгүйгээр сул талбайг ангилан үзүүлнэ.

1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт шигүү барилгажилттай хороолол дахь модлог ургамал болон 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт томоохон хот, суурин газрын хороолол дахь модлог ургамлыг зүг чиг баримжаа заахгүй ганц модны Тэмдгээр дүрсэлнэ. 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр томоохон хотын хороолол дахь дэвсгэр өнгөөр дүрслэгдэх ургамлын бүрхүүлийг дүрслэхдээ ганц модны Тэмдэг хэрэглэхгүй. Зуслангийн хороолол болон хотын захын зуслан маягийн хороололд байгаа мод, жимс жимсгэнэ, алимны модыг байгаа байдлаар нь үзүүлнэ.

26 /B117_A/. Дунд масштабын зурагт барилга, байгууламжийн хорооллыг 2 янзын дэвсгэр өнгөөр дүрсэлнэ.

Шигүү байрлалтай хот, суурины хороолол гэдэгт хоорондоо 50м-ээс холгүй орших барилгажсан хэсэг орно. 1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зурагт хоорондоо 1 ба 2 мм-ээс их (газар дээрээ 50 м-ээс их зайтай) хэмжээтэй суурин газар сийрэг хороололд тооцогдоно.

Шигүү байрлалтай хорооллыг дүрслэхдээ дэвсгэр өнгө нь бүдэг улбар шар, сийрэг барилгатай хорооллын дэвсгэрийг бүдэг шар өнгөөр тус тус дүрсэлнэ. 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр барилгаар нь хорооллыг ангилахгүй.

27 /B119_P/. Дөрвөн цагийн улиралд нүүдэллэн бууж гэр барихад зориулан цутгасан бетон суурь, төмөр-бетоноор цутгасан гэрийг байр зүйн зурагт энэ Тэмдгээр дүрсэлнэ.

28 /B102_T/. Зоорь, хүлэмж, Засаг даргын тамгын газар, эмнэлэг, сургууль гэх мэт барилга байгууламжийн тайлбар бичиглэлийг бичнэ.

### 8.7 Олон нийтийн байгууллага

8.7.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

29-32 /B201_P – B204_P/. Орон сууцны бус Тэмдгээр дүрслэгдсэн барилга, байгууламжид үйл ажиллагаа явуулж буй Нийслэл, хот-аймаг, сум-дүүрэг, баг-хорооны засаг захиргааны төв, нутгийн удирдлагын ордонг дунд масштабын байр зүйн зурагт байрлалаар нь масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ.

### 8.8 Соёл боловсролын байгууллага

8.8.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

33 /B307_P/. Бурхан шашны үйлсэд зориулан барьсан барилгыг (сүм, дуган, хийд гэх мэт) байр зүйн зурагт тогтоосон Тэмдгээр нь дүрслэн үзүүлнэ.

34 /B321_P/. Баримал, хөшөө, багана, (чулуу ба бусад материал орсон) чулуун багана /дайнд оролцогчдын булш, бунхан гэх мэт/ масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ.

### 8.9 Үйлчилгээний байгууллага

8.9.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

35 /B407_P/. Төмөр замын өртөөний Тэмдгийг өртөөний гол барилга (буудал), бусад барилга байгууламж нь бүхэлдээ зургийн масштабд илэрхийлэгдэхгүй тохиолдолд хэрэглэнэ. Өртөөний Тэмдгийг өртөөний гол барилга (буудал) байгаа газарт зурна. Хэрэв төмөр замын гол барилга (буудал) нь төмөр замын шугамаас бага зэрэг алслагдсан (замын Тэмдгийн шугам ба гол барилгын Тэмдэг хоорондох зай 1 мм-ээс их) бол өртөөний Тэмдгийн оронд барилгын дэргэд "*вкз.*", буудлаас өөр томоохон барилга байгууламжгүй өртөөн дээр байгууламжийн дэргэд "*өрт.*" гэж бичнэ.

36 /B409_P/ Аэродром, онгоц буух, нисэх талбайг (хуурай газар ба усан дээр) байрлалынх нь дагуу бусад барилга байгууламжийн (нисэх, буухад үйлчлэх) хамт дүрсэлнэ. Аэродром дахь нисэх-буух зурвас ба онгоц зогсоох талбайн хүрээг 0.15 мм өргөн зураасаар дүрслэх ба онгоц залуурын замыг хатуу хучилттай авто замын Тэмдгээр онгоцны нуувч, засварын газар, радиостанц гэх мэт бусад байгууламжийг зохих барилгын Тэмдгээр үзүүлнэ.

37 /B410_P/ Бензин агуулах сав болон шатахуун түгээх станц (ШТС)-ыг байр зүйн зурагт тэмдэглэхдээ уг байгууламжийн газар дээрх байрлал болон түгээх төхөөрөмжийг үзүүлнэ. Томоохон ШТС-ыг дүрслэхдээ түүнд очих зам түгээх удирдлага, бусад барилга, байгууламжийн хамт үзүүлнэ.

### 8.10 Үйлдвэр худалдаа

8.10.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

38 /B501_P/. Үйлдвэр, цахилгаан станц зэрэг үйлдвэрийн үйлдвэрлэлийн байр гэдэгт цех, машин тоног төхөөрөмжийн байр, бэлэн бүтээгдэхүүний агуулах зэргийг хамруулна.

Үйлдвэр, станц, гурилын тээрмийн масштабын бус Тэмдгийг зургийн масштабд нь дүрслэх боломжгүй яндан бүхий үйлдвэрийн газруудыг дүрслэхэд хэрэглэнэ. Яндан газар дээрээ байгаа байрлал дээр нь уг Тэмдгийг, харин хэд хэдэн яндан нэг дор байвал хамгийн ялгарах яндангийн байрлал дээр тус тус тавина. Яндан нь 30 м-ээс өндөр бол өндрийг нь зааж бичнэ. Зургийн масштабд илэрхийлэгдэх үйлдвэрийн газрууд (яндантай ба яндангүй) уг объектын талбайд орших барилга, яндан болон бусад барилгуудын хашаа, хязгаарыг мөн зохих Тэмдгээр нь дүрсэлнэ. Эдгээр үйлдвэрийн газруудын дүрслэлийн дэргэд уг газрын төрөл, ангилал, үйлдвэрлэлийн онцлогийг тогтоосон журмын дагуу товчлон бичиж (гур.үйлд, арьс.үйлд, гэх мэт) тайлбар өгнө.

39 /B502_P/. Цахилгаан станц (ЦС) гэдэг нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн гаргах үйлдвэрийн газар юм. Байр зүйн зураг дээр усан цахилгаан станц (УЦС)-ыг дүрслэхдээ усан сан, далан ба станцын барилга байгууламжийг байгаа байрлалаар нь үзүүлнэ. УЦС болон бусад ЦС-ын тэмдэгт зохих тайлбар бичиж (*УЦС, ДЦС, АЦС, ЦС. Гэх мэт*) өгнө. 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр ЦС-ын барилга нь 0.8 x 1.2 мм-ээс ихгүй хэмжээгээр дүрслэгдэх тохиолдолд ЦС-ыг масштабын бус Тэмдгээр дүрсэлнэ.

40 /B503_P/. Дэд станц хоёр янз байдаг: хаалттай, ил. Тухайн масштабд илэрхийлэгдэхгүй цахилгааны дэд станц (трансформатор, хувьсагч)-ыг байр зүйн зураг дээр мөн масштабын бус Тэмдгээр үзүүлж дэргэд нь "дэд станц" гэсэн тайлбар бичнэ.

## 8.11 Хашаа, хамгаалалт

8.11.1 Байр зүйн зурагт дүрслэгдэх хашаа хамгаалалтыг тоосго, чулуу, төмөр бетон, төмөр, блок; олон төрлийн суурь ба тулгуур бүхий модон, төмөр хашаа; янз бүрийн хэлбэрийн төмөр утсан хаалт; хайс гэж ялгана.

8.11.2 Тухайн масштабд илэрхийлэгдэх хашааг эгнээгээр, Тэмдгийн чиглэл эгнээний дотор тал руу харсан байхаар үзүүлнэ. 1м болон түүнээс дээш өндөртэйг хашаа, 1м-ээс доош өндөртэй болон сараалжин хэлбэрийн хашааг хайс гэж үзнэ. Хашаа, хайс нь тоосго, бетон, блокон суурь эсвэл баганатай байж болох бөгөөд хашааны үндсэн хэсэг нь ямар материалаар хийгдсэнээр уг хашаа, хайсыг байр зүйн зурагт үзүүлнэ.

8.11.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

41 /B701_L/. Модоор баригдсан 1м болон түүнээс дээш өндөр бүхий хашааг энэ Тэмдгээр дүрсэлнэ.

42-43 /B702_L – B703_L/. Тоосго, чулуу, төмөр бетон, блок хийгдсэн хашаа хамгаалалтыг эдгээр давхаргад дүрсэлнэ.

44 /B704_L/. Төмөр торон хашаа гэж төмөр утсыг нугалж торлосон, янз бүрийн хэлбэртэй хашааг хэлнэ.

45 /B705_L/. 1м-ээс намхан, төмөр, мод, тоосго, блок, бургас зэргээр барьсан сараалжин хашаа нь хайс болно.

46 /B706_P/ Мал хаших зориулалтаар барьсан хашаа, хамгаалалтыг үүнд хамааруулж ойлгоно. Орон нутагт байгаа малын хашааг газар орондоо ямар чигтэй байрлаж байгаагаар нь зурна. Хашааны хэмжээ нь зургийн масштабын хэмжээнээс их бол түүнийг бодит байдлаар дүрсэлж "*хаш.*" гэж тайлбар өгнө. Малын хороо барьсан материалыг ялгаж "*чу.хор*" гэх мэт тайлбар өгнө.

**8.12 Аж үйлдвэрийн байгууламж**

8.12.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

47 /C101_A/. Байр зүйн зураг дээр хураасан нүүрс, элс, хайрга, үртэс, хөрс шороо, хог ургамал, илүүдэл хаягдал материал, ухсан, тэгшилсэн газар гэх мэт объектын хүрээг цэгэн Тэмдгээр зурна. Ил задгай нүүрс, элс, төмөр бетон хавтан гэх мэт материал, бүтээгдэхүүнийг тогтмол нэг газарт хураадаг бол байр зүйн зурагт оруулна. Хог хаях зориулалтын газар нь газар дээрээ тодорхой хүрээ, хязгаартай бол байр зүйн зурагт дүрсэлнэ.

48 /C103_P/. Байр зүйн зурагт газар доорх хатуу ашигт малтмалын орд газраас /уурхай/ зөвхөн уурхайн үндсэн амсрыг байрлалаар нь дүрслэн, олборлож буй бүтээгдэхүүнийг (жишээ нь: Нүүрс, фосфор гэх мэт) бичнэ.

Ажилладаг, ажилладаггүй уурхай ба уурхайн хонгилын амсрыг далд аргаар ашигт малтмал ашигладаг уурхайн ба хонгилын орцыг үзүүлэхэд хэрэглэнэ. Зургийн масштабд дүрслэх боломжгүй ийм төрлийн үйлдвэрийн уурхай, хонгил (ажилладаг, ажилладаггүй)-ын амсрын Тэмдгийг уг уурхайн өргөх төхөөрөмж ба хонгилын орц байгаа газар дээр нь байрлуулна. Хэрэв уурхай ба хонгилын орц нь байшин дотор байвал барилгыг нь үзүүлнэ. Эдгээр Тэмдгийн дэргэд уг үйлдвэрийн бүтээгдэхүүний төрлийг заавал бичиж (нүүрс, фос. гэх мэт) өгнө. Уурхайн өргөх төхөөрөмжийн өндөр нь 30 м ба түүнээс их бол заавал өндрийг нь бичнэ. Тухайн масштабд илэрхийлэгдэх ашигт малтмалын үйлдвэрийг /B501_P/ заасны дагуу дүрсэлнэ. Энэ тохиолдолд уурхайн хонгил (ажилладаг, ажилладаггүй)-ын амсрыг үзүүлэх ба тайлбар бичиглэл өгнө.

49 /C105_P/. Амсарт уурхай, цооног, шурф нь нурсан бол байр зүйн зурагт нэг янзын Тэмдгээр дүрсэлж, нүхний гүнийг м-ээр үзүүлж тайлбар бичиглэлийг ("нур.") өгнө.

50 /C101_T/ Аж үйлдвэрийн байгууламжийн хажууд бичигдэх тайлбар бичиглэлийг энэ давхаргад бичнэ. Жич: *хайгуул. ашиг.*

**8.13 Цахилгаан, холбооны байгууламж**

8.13.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утганд дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

51-54 /C204_L – C207_L/. Цахилгаан дамжуулах шугам нь (ЦДШ) сувгийн, утсан гэсэн 2 төрөл байдаг бөгөөд өндөр ба нам хүчдэлийн (380 Вт ба түүнээс бага) гэж хоёр ангилан байр зүйн зурагт үзүүлнэ. Дунд масштабын байр зүйн зурагт зэрэгцээ хэд хэдэн ЦДШ-ыг томоохон тулгуур бүхий шугам буюу хүчдэл ихтэй шугамыг сонгон дүрсэлнэ.

ЦДШ-ын утас, кабель болон холбооны шугам нь нэг тулгуур дээр бэхлэгдсэн тохиолдолд байр зүйн зураг дээр зөвхөн ЦДШ-ыг дүрсэлнэ.

14 метрээс бага өндөртэй модон ба бетон тулгуур дээрх ЦДШ-ын Тэмдгийн цэгүүдийг 16 мм тутамд зурна. Ямар ч тохиолдолд ЦДШ-ын эргэлтийг байр зүйн зураг дээр үзүүлнэ.

ЦДШ-ын төмөр ба төмөр бетон шонгийн дүрслэлийн 6-8 см тутамд тулгуурын өндрийг метрээр бичнэ.

Төмөр ба төмөр бетон тулгууртай 35 кВт ба түүнээс их хүчдэлтэй ЦДШ-ыг түүний шугамын дагуу хүчдэлийг (кВт-аар) зааж бичнэ. Ихээхэн урт шугамын 15-20 см тутамд хүчдэлийн бичиглэлийг өгнө.

Тус тусдаа тулгуууртай боловч нэгэн зэрэгцээ (хоёроос гурван) орших (хоорондох зай нь зургийн масштабд 0.8 мм-ээс бага бол) ЦДШ-ыг нэг Тэмдгээр дүрсэлж утасны тоог бичнэ. Жишээ нь: зэрэгцээ хоёр ЦДШ-ын байрлалыг аль

нэгийг нь байрлалаар, гурван ЦДШ байвал дундах шугамын байрлалаар тус тус дүрсэлнэ. Хэд хэдэн ЦДШ-ын дүрслэлийг илэрхийлж, нэг Тэмдгийн дэргэд шугамын тоо, шугам бүрийн хүчдэлийг заан бичнэ. Жишээ нь: 2ЦДШ-110 кВт эсвэл 2 ЦДШ-150 ба 110 кВт гэж бичнэ.

Газар доорх цахилгааны кабелийг агаарын цахилгааны шугамын нэгэн адил өндөр ба нам хүчдэлийн гэж ангилна. Зөвхөн өндөр хүчдэлийн шугамын хүчдэлийг үзүүлнэ. ЦДШ-ын хүчдэлийг /кВт/ мэдээлэлд оруулж өгнө.

55-58 /C208_L, C211_L/. Холбооны шугам ба удирдлагын техник хэрэгслийн шугамын төрөлд цахилгаан мэдээний, утсан харилцааны, радио нэвтрүүлгийн, телевизийн, телетайпын, дохиоллын гэх мэт шугамыг нэг төрлийн Тэмдгээр дүрсэлнэ.

Газар доорх шилэн кабелийг байр зүйн зурагт үргэлжилсэн тасархай шугамаар байрлалаар нь дүрсэлнэ.

Холбооны шугам, цахилгаан дамжуулах шугамын (ЦДШ) Тэмдгийг хот, суурин газар болон төмөр зам, авто зам дээгүүр давхцуулж зурахгүй.

59 /C212_P/. Радио телевиз, радиогийн цамхаг, радиорелей, радио өргөн нэвтрүүлгийн цамхгийг дүрслэхэд нэг төрлийн Тэмдэг хэрэглэнэ. Радио, телевизийн цамхгийн Тэмдгийг зөвхөн телевизийн буюу радиогийн цамхаг уг станцын барилга дээр буюу түүнд залгаа байдлаар баригдсан тохиолдолд хэрэглэнэ. Радио станц (телевизийн төв)-ын цамхгийн дэргэд тайлбар бичнэ. Тухайлбал: "*радио ст, теле.төв*" гэх мэт.

60 /C213_P/. Мэдээллийг алсад дамжуулахад радио долгионы тархалтыг ашиглаж байгаа холбооны системийг утасгүй холбоо буюу үүрэн холбоо гэж нэрлэдэг. Үүрэн холбооны антеныг байр зүйн зурагт байрлалаар нь цэгэн Тэмдгээр тэмдэглэн ямар үүрэн холбооны операторын антен болохыг мэдээлэлд оруулж өгнө

61 /C215_P/. Салхин сэнсийг овор хэмжээ, зургийн масштабаас хамааруулж зохих Тэмдгээр нь дүрслэх бөгөөд тайлбар бичиглэл өгч болно.

62 /C216P/ Нарны энергийг хуримтлуулж эрчим хүч гаргах зориулалттай байрлуулсан зай хураагуур юм.

63-64 /C200_T - C201_T/. Цахилгаан, холбооны байгууламжийн тайлбар бичиглэл, үзүүлэлт энэ давхаргад бичигдэнэ. Жич: *рад. тр. дэд.ст. каб. 8Вт*

### 8.14 Ус, цаг уур

8.14.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

65 /C401_P/. Цаг уурын ажиглалтын станцын Тэмдгийг ажиглалтын талбайн гол хавьд байгаа багаж хэрэгслийн дэргэд өгнө. Хэрэв ажиглалтын талбайг тухайн масштабд (3*3 мм ба их) илэрхийлэх боломжтой бол станцын талбайг зурж, Тэмдгийг салхины чигийг заагчийн байран дээр зурна.

66 /C400_T/ Ус, цаг уурын зориулалттай элементүүдийн хажууд бичигдэх тайлбар бичиглэл уг давхаргад бичигдэнэ. Цаг уурын станц нь барилгын дээвэр дээр байвал уг байшинг үзүүлж "*цаг уур.ст.*" гэсэн тайлбар өгнө.

### 8.15 Ус зүй

8.15.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

67-68 /E101_A – E101_L/. Гол мөрөн, нуурын эргийн шугам байр зүйн зурагт бодит байрлалыг илэрхийлэхээс гадна усны хамгийн тогтвортой үеийн түвшинг

үзүүлнэ. Ус урсгуур, усан тогтцын эргийн шугамыг байр зүйн зурагт 3 хэсэг болгон хувааж, бие даасан Тэмдгээр тэмдэглэнэ:

1) байнгын ба тогтвортой;

2) тодорхой бус буюу байнга өөрчлөгддөг;

3) жилийн зарим цаг үед устай байдаг боловч эрэг, голдрил нь мэдэгдэхүйц гол, нуур цөөрмийн тогтворгүй эргийн шугам.

Байнгын тогтвортой эргийн шугамыг байр зүйн зурагт үргэлжилсэн шугамаар, хатдаг, ширгэдэг бол тасархай шугамаар үзүүлнэ.

Голын өргөнөөс хамаарч түүнийг нэг буюу хоёр шулуун (зурвас)-аар үзүүлнэ. Нэг шулуунаар дүрслэхдээ голын эхээс адаг хүртэл аажмаар өргөсгөнө. Адаг нь элсэнд шурган замхардаг голын шулуун нь эхнээсээ адаг руугаа аажмаар нарийсна. Нэг шулуунаар дүрслэх голын шулууны өргөн нь эхэндээ 1.5 мм-ээс багагүй, адагтаа 0.2-0.5 мм хүртэл байх бөгөөд хоёр шулуунаар дүрслэхээр шилжвэл 0.5 мм байна. Тухайн масштабд илэрхийлэгдэхгүй хоёр шулуунаар зурагдах голын шулуун бүрийн өргөн нь 0.1 мм, хоорондох завсрын өргөн нь 0.3 мм байна. 1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр тус бүр 15, 30 ба 60 мм-ээс өргөн голыг жинхэнэ байгаа өргөнөөр нь байр зүйн зурагт оруулж 0.15 мм өргөн шулуунаар дүрсэлнэ. Энэ тохиолдолд эргийн шугам хоорондох завсрын өргөн нь 0.4 мм-ээс багагүй байна.

Байр зүйн зурагт урсгал усны ёроолын хөрсийг доорх байдлаар ангилна. Үүнд:

- чулуулаг (тэгш бус хадан гадарга, том чулуунууд) үүнийг байр зүйн зурагт "Ч" үсгээр, хатуу (жижиг чулуун ба дагширсан шавар) үүнийг "Х" үсгээр, дагтаршсан элсэн, үүнийг "Э" үсгээр, лаг шаварлаг (лаг шавар, шаварлаг) үүнийг "Л" үсгээр тус тус ангилж тэмдэглэнэ.

69-70 /E102_A – E102_L/. Хатдаг, ширгэдэг голын эргийн шугамыг тасархай шугамаар дүрсэлнэ. Ширгэдэг гол, горхийг нэг ба хоёр шулуунаар түүний өргөнөөс хамааруулж зурах бөгөөд /E101_A/-д дурдсан зарчмын дагуу (эхнээсээ адаг хүртэл шулуун нь өргөснө) дүрсэлнэ. Нэг шулуунаар дүрслэгдэх ширгэдэг гол, горхины эхнээс адаг хүртэлх өргөн нь 1.0-2.0 мм өргөн, хоорондох завсрын өргөн нь 0.5 мм орчим, нэлээд урт гол, горхинд эдгээр хэмжээ нь 3.0 мм хүртэл, завсар нь 1.0 мм байна.

Байнгын бус эргийн шугамын Тэмдгийг 1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зураг дээр ширгэдэг нуур, голын эргийн шугам болон усаар дүүргэж буй усан сангийн эрэг (зураглал авч байх үеийн)-ийг үзүүлэхэд хэрэглэнэ. Харин усан сангийн түвшин төлөвлөсөн төслийн хэмжээнд хүрээгүй, цаашид хүрсэн хэмжээндээ нэмэгдээгүй бол байнгын ба өөрчлөгдөхгүй эргийн шугамаар дүрсэлнэ.

Тодорхой бус эргийн шугамын Тэмдгийг 1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зураг дээр нам дор газрын хатаж буй тэнгисийн эрэг, намаг доторх нуур, голын эргийг дүрслэхэд тус тус хэрэглэнэ.

Жижиг болон томоохон ус зүйн элементүүдийг дүрслэхэд холбоос ба завсрын хэмжээнүүд нь хүснэгтэд заасан хэмжээнд (мм) хүртэл ихсэх буюу багасаж болно.

71-72 /E103_A – E104_A/. 1:25 000 - 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт бүх нууруудыг оруулна. Эмчилгээний зориулалттай нуурын талбайг нь тусгайлан томсгож үзүүлэх тал бий. Нэргүй, тодорхой заагтай гүехэн нуурыг ойр орчмын объектуудаас ялган үзүүлэхийн тулд "нуур" эсвэл "Н." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Шорвог, давстай нуурыг "давстай" гэх мэт тайлбар өгөх ба тухайн нуур нэртэй бол нэрийн ард нь "Буйр н. (давстай)" гэсэн тайлбар бичиглэлийг хийнэ.

| д/д | Зургийн масштабт дүрслэгдэж буй ус зүйн элементийн нэр | Ус зүйн элементийг дүрслэх Тэмдгийн хэмжээ | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Жижиг | | Томоохон | |
| | | холбоосын урт | завсрын хэмжээ | холбоосын урт | Завс-рын хэмжээ |
| | 1:25 000, 1:50 000 | | | | |
| 1 | Байнгын бус эргийн шугам (хатаж буй гол, нуур) | 1.0 | 0.5 | 3.0 | 1.0 |
| 2 | Тодорхой бус эргийн шугам (хатаж буй тэнгисийн эрэг, намаг дахь гол, нуурын эрэг, усан сангийн эрэг) | 2.0 | 0.5 | 5.0 | 1.0 |
| | 1:100 000 | | | | |
| 3 | Байнгын бус, тодорхой бус эргийн шугам | 1.0 | 0.5 | 3.0 | 1.0 |

73 /E106_P/. Зураглалын ажлын даалгаврын дагуу усны түвшний өндрийг байр зүйн зурагт оруулахдаа зураглал үйлдсэн он, сар, өдрийн байдлаар буюу олон сарын дундаж түвшнээр үзүүлнэ. Усны түвшний өндрийг 0.1 м -ийн нарийвчлалтай тодорхойлно. Урсгуурын (налуу багатай) түвшний өндрийг тусгай шаардлагаар тодорхойлно.

74 /E108_L/. Урсгал усны чиглэлийг усан дээр сумаар, өргөнтэй нь харьцуулан зурж үзүүлэх ба хэрэв гол нь тухайн масштабаар илэрхийлэгдэхгүй бол голдрилыг дагуулан зурна.

Усны урсгалын хурд нь байр зүйн зураглалын явцад хэд хэдэн удаа тодорхойлогдсон эсвэл ус зүйн материалд үндэслэгдсэн усны гадарга дээрх дундаж хурд болно. Урсгалын чиглэл, хурдны тодорхойлолтыг байр зүйн зурагт 10-15 см тутамд мөн эхэн ба төгсгөлд (хаалт далангийн дээр, доор, хүрхрээ зэрэгт) голын уулзвар хэсэгт өгнө. Чиг заадаг сумны урт 5-15 мм хүртэл байх бөгөөд голын хэмжээнээс хамааруулан үзүүлнэ.

75 /E109_P/. Байгалийн булаг, шандыг байр зүйн зурагт масштабын бус Тэмдгээр урсгалын чигийг харгалзан үзүүлнэ.

Байгалийн бүх төрлийн булаг шандыг үзүүлэхэд тайлбар бичиглэл хэрэглэнэ. Ердийн устай булаг шандад "бул. шанд" гэх мэт тайлбар бичиглэлийг өгнө. Эрдэстэй булаг шандад эрдсийг нь "нүүрс ус", "хүхэр" гэх мэт заах ба эрдэс нь тодорхойгүй бол "эрдэст" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Ус багатай газар нутгийн булаг шандад ус хангамжийн өгөгдлийн дагуу ундаргыг л/цаг-аар тодорхойлно. Булаг шандны дэргэд гадаргын үнэмлэхүй өндрийг бичнэ.

76 /E110_P/. Халуун уур, ус байнга оргилон гарахыг оргилдог рашаан гэнэ. Оргилдог рашааныг Тэмдгээр үзүүлж гадаргын үнэмлэхүй өндрийг тодорхойлно.

77-78 /E111_A – E112_A/. Намгийг байр зүйн зурагт байнгын ихээхэн чийглэгтэй, намгийн ургамалтай 30 см түүнээс зузаан хүлэр давхаргатай (хүлэр тогтох аятай нөхцөл бүрдээгүй, тал болон өндөр уулын намгаас бусад) газрыг хамруулан үзүүлнэ. Намгийг жилийн тунадас, улирлын мөчлөг, туулах (нэвтрэх) боломжоор нь хувааж үзүүлдэг. Гатлах боломжтой намагт хүн дуртай чиглэлд чөлөөтэй туулж болох намаг хамаарна. Бусад төрлийн намгийг гаталшгүй, гатлахад хүнд гэсэн Тэмдгээр үзүүлнэ. Намаг, марз (зургийн масштабд 1 см.кв-аас бага)-ыг дүрслэхдээ 1:25 000-ны масштабтай зураг дээр Тэмдгийн зураас

хоорондох зайг 0.8 мм хүртэл, 1:50 000 ба 1:100 000-ны масштабтай зурагт 0.6 мм хүртэл багасгаж болно.

Гатлах боломж нь янз бүр намаг бүхий газрыг тэдгээр нь зурагт 1 см.кв, түүнээс томоор үзүүлэгдэх тохиолдолд зааглан зурна.

Байр зүйн зурагт хэрэглэгдэх намгийн гүний үзүүлэлт нь гадаргын бүрхүүл, эрдсийн ёроол хүртэлх хүлрийн зузаан зэргийн нийлбэр бөгөөд энэ нь намгийн гатлах шалгууртай шууд холбогдолгүй. Намгийн үзүүлэлтийг 2.5 м хүртэлх гүнийг нь хэмжсэний үндсэн дээр 0.1 м нарийвчлалтайгаар тогтооно. Хэрэв хүлрийн зузаан 2.5 м-ээс их бол "2.5 м-ээс гүн" гэсэн бичиглэл хийнэ. Хүлэр хайгуулын ажилтай холбогдсон газрын хувьд намгийн гүнийг бодит гүнээр нь (-4.5 м гэх мэт) тогтооно. 50 см.кв хүртэл талбай эзлэх намагтай газарт гүний хэмжээг түүний хамгийн гүн хэсэгт нь бичнэ. Үүнээс их талбайд 1-2 Тэмдгийг 1 дм.кв бичнэ.

Намаг нь үргэлж ургамлаар бүрхэгдсэн байдаг тул тэдгээрийг хөвдтэй, тачир өвстэй, өндөр өвстэй, буттай, сөөгтэй гэх мэтээр ангилна, ургамлын төрлийн Тэмдгийг тухайн талбайд байрлуулж зурна. Намаг доторх ургамлын Тэмдгийг тодорхой хуваарилалтгүй зурна. Намагтай хослуулан ургамлаас гадна бусад (бут, сөөг, дов) ургамал, хөрсийг хослуулан хэрэглэнэ.

79-80 /E114_A – E115_A/. Гатлах боломжтой, гатлахад хүнд, хужир, марзын Тэмдгийг байр зүйн зурагт үйрмэг хөрс, нойтон хөөмөл (дулааны улиралд), хужир, марз, мөн усан тогтцын эргээр тогтож хатсан давслаг шавар зэрэгт хэрэглэнэ. Нэвтрэх боломжийг ялган хүн нэвтэрч чадах боломжоор үнэлнэ. Гатлах боломжтой хужир, марз бүхий газарт давслаг хөрстэй, хатуу гадаргатай, ургамалгүй, гадарга дээр нь давсны зурвас үүссэн, бут сөөг тохиолдох газар хамаарна. Гаталж болох томоохон хэмжээний хужир, марзыг онцгой Тэмдгээр тэмдэглэнэ. Хэрэв байр зүйн зурагт 1 см.кв, түүнээс томоор дүрслэгдэх тодорхой хязгаартай бол түүнийг үзүүлнэ.

81 /E116_L/. Байр зүйн зурагт уулын болон нууруудын дундах ижил бус түвшинтэй хүрхрээнүүдийг үзүүлнэ. Цас хайлалт болон борооны дараа үүсдэг байнгын бус хүрхрээг байр зүйн зурагт үзүүлэх шаардлагагүй.

Голын хүрхрээ, боргиог "*хүрх.*", "*борг.*" гэж товчлон бичих ба өндрийг (м) бичнэ. Зургийн масштабд 2 мм-ээс бага өргөнтэй голын болон нэг шугамаар дүрслэгдэх голд хүрхрээ, боргиог хөндлөн зураасаар зурна.

82-84 /E101_T, E106_T, E108_T/. Нуур, гол, булаг зэрэг ус зүйн элементүүдийн оноосон нэр, үзүүлэлт болон усны урсгалын хурд зэрэг нь эдгээр давхаргад бичигдэнэ.

## 8.16 Усны байгууламжууд

8.16.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

85-88 /E201_P – E204_P/. Гар, мотортой, эргүүлдэг, дүүжин /салхин хөдөлгүүртэй/ худаг, усны бусад эх үүсвэрийн дэргэд эдгээрийн үзүүлэлтийг бичнэ. Тухайлбал: газрын түвшний тоот, худгийн гүн (м), усны чанар (давстай, шорвог), худгийн ус дүүрэлт буюу ундарга (л/цаг). Мөн усгүй худагт "*дар.худ*" гэж тайлбар өгнө.

Тогтоосон нэргүй худгийн Тэмдгийн дэргэд "*Х.*", гэсэн хураангуйлсан нэр буюу тодорхой нэрийг байрлуулна. Давстай, шорвог устай худагт "*давст*", эсвэл "*шорв.*" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

Дунд масштабтай байр зүйн зурагт худгийн тодорхойлолтыг зөвхөн нэмэлт шаардлагаар үзүүлнэ. Гэхдээ хуваарьт - худгийн тодорхойлолтыг, хүртвэрт – гүнийг бичнэ. Худгуудын ундаргыг л/цаг-аар тодорхойлно.

Дарагдсан худагт "*Х.*" (*дар.*) гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

89 /E207_L/. Гатлага төхөөрөмжийг өөрөө явагч буюу механик хөдөлгүүртэй гатлага онгоц, өөрөө явагч буюу чиргүүл, тросс зэргийн тусламжтай ажиллах сал, бярвааз, хөвөгч гэх мэт ангилна. Эдгээр гатлагууд байр зүйн зурагт Тэмдэг, урт, өргөн, даацын тодорхойлолтын хамт үзүүлж "*гат.*" эсвэл "*бяр.*" гэсэн тайлбар бичиглэлтэй байна.

90 /E208_L/. Голын олом, гармын Тэмдгийг газар дээрх бодит байрлалаар нь байр зүйн зурагт үзүүлнэ. Голын шулуун гарам (олом)-ыг тасархай шулуунаар зурж "*гарам*" гэж бичнэ. Гармын тэмдэг голын нэгэн адил тодорхойлолттой байна. 5 м ба түүнээс өргөн голын олмын дэргэд түүний үзүүлэлтийг бичнэ. Хүртвэрт гүн (0.1 м хүртэл нарийвчлалтай) ба өргөн (метр хүртэл), хуваарьт ёроолын хөрсний төрөл, усны хурд (м/сек)-ыг бичнэ. Жишээ нь: Хөрсийг чулуулаг, хатуулаг, элсэрхэг, шаварлаг гэж хуваана.

91 /E214_P/. Тоноглогдоогүй зогсоол цэгийг байр зүйн зурагт зангуу хэлбэрийн тусгай Тэмдгээр, эргийн шугамын ойр усны мандлын дүрслэлд зурж үзүүлнэ.

92-95 /E201_T, E202_T, E206_T, E208_T/. Худгийн оноосон нэр, үзүүлэлт, олом гарамны үзүүлэлт, усны бусад байгууламжийн хажууд бичигдэх тайлбар бичиглэлүүд эдгээр давхаргад орно.

### 8.17 Мөнх цас, мөсөн гол

8.17.1 Уулын оройд цасан дээр цасны нягтралаас үүссэн бутрамтгай талст бүхий мөслөг давхаргыг мөнх цас гэнэ. Мөнх цасны гадарга нь мөсөн голын эх болох бөгөөд энэ нь гүнзгий хагаралтай тогтсон байдаг. Дунд масштабын байр зүйн зурагт мөнх цасыг байгаа байдал, эзлэх талбайгаар нь Тэмдгээр зурж үзүүлнэ.

8.17.2 Мөнх цас, цасан уулын хилийг цэнхэр өнгийн цэгээр зурна. Мөсний "эх"-ийг цэнхэр өнгийн нарийн шулуунаар зурна. Мөсөн талбай цасан уулыг хооронд нь зааглахгүй. Ханан хад /байц/-ыг дүрслэхэд хаялбар хоорондох зай нь 0.2 мм-ээс бага бол хаялбарыг нийлүүлж зурах (хэрэв ийм тогтцын урт нь зургийн масштабд 1 см-ээс бага бол) буюу өргөсгөсөн хаялбарын хооронд дөрөв биш гурав ба хоёр хаялбар (ийм хэсэг газрын урт нь 1 см-ээс их бол) татаж бусад хаялбаруудыг тасархай шугамаар зурна. Мөргөцгийг (дэвсэг) дүрслэхэд хаялбарыг тасалдалгүй зурна.

8.17.3 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

96-98 /E301_L – E303_L/. Уулын хөндийг дагаж урсаж сунасан, зарим хэсэгтээ дагуу ба хөндлөн хагаралтай, цасан нягтрал бүхий бөөгнөрлийг мөсөн гол гэнэ. Мөсөн гол, мөнх сарьдгийн хязгаарыг аль болох бүтэн тодорхой үзүүлэх хэрэгтэй. Ялангуяа цасанд түрэгдсэн чулуулаг эсвэл цасан бөөгнөрлийг ялган үзүүлэх нь чухал юм. Мөсөн голын хилийн доод төгсгөлд өндрийг заавал тодорхойлно.

99 /E305_P/. Хэдэн м-ээс хэд хэдэн зуун м-ийн гүнтэй, 3-5 м түүнээс өргөн диаметртэй, гол төлөв босоо дугуй хэлбэрийн нүхийг, мөсөн голын худаг гэнэ. Энэ нь усны хайлалтаас мөсөн голын хагарал дотор үүснэ. Мөсөн голын худгийн гүнийг шаардлагатай бол 1.0 м нарийвчлалтай үзүүлнэ.

100 /E306_A/. Жилийн дулаан улиралд ч хайлдаггүй цасан бүрхэвч хөр цасыг байр зүйн зурагт үзүүлнэ. Өөрөөр хэлбэл дулаан улиралд цас бүрэн хайлсны дараа үлдсэн хөр цас болно.

101 /E306_T/. Мөнх цас, мөсөн голын тайлбар бичиглэл энэ давхаргад бичигдэнэ. Жич: *дошин., мөс.овоол.*

**8.18 Газрын гадарга**

8.18.1 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

102-105 /F101_L- F104_L/. Хаялбарыг бүх төрлийн байр зүйн зурагт газрын гадаргыг дүрслэхэд зориулан зурна.

Нэмэлт хаялбарыг газрын хотгор гүдгэр хэлбэр үндсэн хаялбараар дүрслэгдэхгүй бол хэрэглэнэ.

Туслах хаялбар нь байр зүйн зургийн хамгийн өндөр оргил, хамгийн хонхор газар, газрын гадаргын бичил хаялбарыг (тухайлбал: ганга жалга гэх мэт) үзүүлэхэд ашиглагдана. Туслах хаялбар дурын өндөртэй зурагдана.

Үндсэн, нэмэлт (хагас хаялбар) ба туслах хаялбарыг байр зүйн зургийн эх дээр 0.1 мм-ээс өргөн зураасаар зурна. Өргөсгөсөн хаялбарын өргөн нь 0.2 мм байна.

Хаялбарыг (хоёр шулуунаар дүрслэх голоос бусад) зургийн масштабд 3 мм-ээс багагүй илэрхийлэгдэх ганга, жалга, гуу болон нүх ухсан газар, далан, дов сондуул, элс, нүүрс, шороо, олборлодог ил уурхай зэрэг объект дээгүүр тасалдалгүй зурна.

Хаялбарын өндрийг өндөрлөг чиглэл уруу, байр зүйн зургийн доод ба зүүн захыг дагуулан бичнэ. Хаялбарын өндрийг тухайн байр зүйн зурагт байгаа өндрийн цэгүүдтэй холбон ямар ч цэгийн өндрийг хурдан тодорхойлох нөхцөлийг харгалзан өгнө.

106 /F105_L/. Ус хагалбарын шугамыг (бергштрих) хаялбарт, хотгор гүдгэрийг тодотгох, оргил, хонхор зэргийг бага налуутай газар мөн байр зүйн зургийн захын хэсэгт 0.6 мм урттай зурж үзүүлнэ.

107 /F106_P/. Байр зүйн зурагт өндрийн цэгүүдийн тоог ажлын даалгаварт заах бөгөөд эдгээр нь байр зүйн зурагт тодорхой цэгүүдийг оролцуулан дунджаар 1 дм.кв-д 5-15 цэг байна.

108 /F107_L/. Олон жил усны үйлчлэлээр идэгдэж эвдэрсэн газрыг байр зүйн зурагт ганга, нарийн жалга, гуу, идэгдсэн гуу гэж ангилахаас гадна энэ хэлбэрт хуурай голдрил, үйрмэг шороо зэрэг хамаарна. Жалгын уртыг илэрхийлж байгаа зураасны урт нь дүрслэгдэж буй жалганы хавтгайд буулгасан тусгаг болно.

1:25 000, 1.50 000-ны масштабтай байр зүйн зурагт өргөн нь 5 м, 1:100 000-ны масштабтай зурагт 10 м хүртэл өргөн судаг, жалгыг нэг шулуунаар зурна. Үүнээс өргөн бол хоёр шулуунаар зурна. Зургийн масштабд 1 мм ба түүнээс өргөн дүрслэгдэх жалгыг хоёр шулуунаар шүдтэй зурна. Жалгын ёроолын өргөн нь 3 мм ба түүнээс их бол хаялбар татна. Жалга, гууны дүрслэлийн дэргэд өргөн - (дээд талын), гүн (м)-ийг бичнэ.

109-110 /F108_A - F108_L/. Цаг үеийн усны нөлөөллөөр үүссэн жижиг хуурай гулдрал, үйрмэг шороо зэрэг нь ганга, голын дэнж, хөндийн хэвгий зэрэг ус хагалбарын зайнд тохиолдоно. Гадаргын ийм хэлбэрийг байр зүйн зурагт 0.2-0.5 мм хүртэл хос тасархай шугамаар эсвэл өргөн нь масштабд илэрхийлэгдэж байвал усны элэгдэл, сайр мэтээр ерөнхийлөн дүрсэлнэ. Үүнээс ялгагдах том гол мөрний хуурай голдрилыг газар дээрх байршлын дагуу зурж, эргийг хаялбартай уялдуулна.

Голын хуурай голдрилыг түүний өргөнөөс хамааруулж нэг буюу хоёр шулуунаар дүрслэх бөгөөд голын эхнээс адаг руу нь аажмаар өргөсгөж зурна. Хуурай голдрилын Тэмдгийн холбоосны уртыг ширгэсэн нуур, голыг дүрслэх загварын дагуу тогтооно. Зургийн масштаб хуурай голдрилын өргөн нь 3 мм ба түүнээс их бол эргийн шугам хооронд хаялбар татах бөгөөд 1.5 мм ба түүнээс их өргөнтэй бол зохих Тэмдгээр нь зурж ёроолын хөрсний (элс, хайрга, чулуу гэх мэт) төрлийг бичнэ. Ийм маягаар хатсан нуурын ёроолын хөрсийг үзүүлнэ. Хэрэв

хатсан нуур, хуурай голдрилын ёроолын хөрсний тухай мэдээлэл байхгүй бол эргийн шугам хооронд дан элс зурна.

111 /F109_P/. Байр зүйн зурагт тэмдэглэгдэх даваа нь тухайн давааны хамгийн өндөр цэгтэй уялдах ёстой. Тэмдгийн дэргэд хүртвэрт - давааны өндрийг, хуваарьт- давааны ашиглагдах (давааг давж болох) хугацааг бичнэ.

112 /F111_L/. Голын булан тохойн 1.5 мм түүнээс бага өргөнтэйгөөр дүрслэх хаялгагүй эгц эргийг дор дурдсан байдлаар байр зүйн зурагт оруулна.

- оройн эргийг хавтгайд буулгах, эргийн шугам хоёрын зай 1 мм-ээс их байвал, эдгээр үүссэн шугам хооронд эгц эргийг хоёр зураасаар тэмдэглэнэ.

- хэрэв энэ зай 1 мм-ээс бага бол нэг зураасаар тэмдэглэх ба байр зүйн зурагт дээд ирмэг, эрэг зохих байдлаар орсон байх ёстой.

113 /F112_L/. Хадтай эрэг, жалга нь тодорхой дүрслэгдэх хэмжээтэй, тусгаг нь тухайн масштабд 2 мм-ээс ихээр дүрслэгдэх бол зохих тогтоогдсон Тэмдгээр үзүүлнэ. Хэрэв бага гүнтэй, хөрсөн жалгыг Тэмдгээр үзүүлбэл хар өнгөөр "хад." гэсэн тайлбар бичнэ. Хадтай жалганы байр зүйн зураг дээрх дүрслэл нь агаараас авсан дүрслэлтэй тохирох ёстой.

114 /F113_P/. Ганц нэгээр газраас огцом ил гарсан, богино хэмжээтэй цувраа хадыг үлдэц хад гэнэ. Үлдэц хадны Тэмдгийг газар оронд баримжаа болох үлдэц цохионд хэрэглэнэ. Тэдгээрт "үлд. хад" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. 1 м-ээс өндөр үлдэц хадны өндрийг тодорхойлж байр зүйн зурагт оруулна.

115 /F114_P/. Чулуун давс, шохойн чулуу, доломит, гөлтгөнө зэрэг чулуулаг, усны нөлөөлөлд идэгдэн шовгор болон ухагдаж хонхойсон байгалийн тогтоц (шувтан нүх, зургийн масштабд илэрхийлэгдэх ан цав гэх мэт), мөн хүний үйл ажиллагаагаар бий болсон (олборлолт, эвдэрсэн газар, зоорь гэх мэт) янз бүрийн нүх зэргийг дүрслэх Тэмдэг. Энэ нь хөндлөн огтлолоороо тухайн масштабт 2 мм-ээс багагүй дүрслэгдэж байвал тусгай Тэмдгээр дүрсэлнэ.

116 /F115_P/. Байгалийн үүсэлтэй хаялбараар илэрхийлэгдэхгүй довыг масштабын бус Тэмдгээр байр зүйн зурагт үзүүлнэ. Үргэлжилсэн хэлбэртэй бол /Тэмдэг F209_A/ доворхог гадаргын Тэмдгээр зурна.

117 /F116_P/. Агуйг байр зүйн зурагт оруулахдаа байршлаар нь оруулж "*агуй*" гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

118 /F117_P/. Чиг баримжаа болох сондгой чулууг байр зүйн зурагт масштабын бус Тэмдгээр үзүүлнэ. Сондгой хадны Тэмдгийг ганц нэгээрээ таруу орших том хад, багширсан чулуутай газарт хэрэглэнэ.

119 /F118_L/. Нарийхан цувраа байрласан, орчин тойрондоо мэдэгдэхүйц өндөр, газрын хэвгийтэй уялдаагүй, овоолго чулуулгийг сэврэй хад гэнэ. Сэврэй хадыг тухайн масштабт илэрхийлэгдэхгүй тохиолдолд далан мэт хос шугамаар тэмдэглэнэ. Тогтоц болон өндрөөрөө томоохон дэл хаданд түүний өндрийг зааж бичнэ.

120 /F119_L/. Сөнөсөн галт уулын тогоо бэл орчмын нурмаар дүүрсэн царыг байр зүйн зурагт тэдгээрийн хэмжээ, чулуулгийн бүтцийг харгалзан битүү ба хагас битүү шороон болон хадан жалга мэт дүрсэлнэ. Зургийн масштабт илэрхийлэгдэх галт уулын тогоог хаялбараар дүрсэлнэ (хэрэв тогооны дотор тал нь хэвгий налуу бол).

Ганц нэгээр байрлах сөнөсөн галт ууланд "*сөн.гал.уул.*" хэд хэдэн галт ууланд "*сөн.гал.уулууд*" гэж тайлбар өгнө. Бололцоотой нөхцөлд галт уулын царын ёроол ба ирмэгийн үнэмлэхүй өндрийг, жижиг тогооны харьцангуй гүнийг тодорхойлно.

121 /F122_L/. Байгалийн үүсэлтэй шороон хөмгийн Тэмдгийг далан хаялбараар илэрхийлэгдэхгүй тохиолдолд хэрэглэнэ.

122 /F123_L/. Хаялбараар илэрхийлэгдэхгүй тодорхой бус эрэг, түүний эргэлт тухайн масштабт 0.5 см ба түүнээс их бол мөргөцгийн Тэмдгээр тэмдэглэнэ. Эдгээр мөргөцгийн дүрслэл хаялбарын шугамтай огтлолцож болно.

123-127 /F101_T, F106_T, F107_T, F110_T, F113_T/. Хаялбарын өндөр, өндрийн тоот, газрын гадарга дээрх элементийн нэр, үзүүлэлт зэрэг нь эдгээр давхаргуудад зохих ёсоор бичигдэнэ.

**8.19 Хөрс , газрын бичил гадарга**

8.19.1 Хэрэв тухайн масштабын байр зүйн зурагт гадаргын бичил хэлбэр, хөрс 1 см.кв-аас их талбайгаар үзүүлэгдэх бол тэдгээрийг байр зүйн зурагт зааглан үзүүлнэ.

8.19.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

128-129 /F201_A – F201_P/. Элсний гадаргын хэлбэр дүрсийг 1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт хаялбараар дүрслэх бөгөөд элстэй хөрсийг элсний гадаргын хэлбэр дүрсийг харуулахад хэрэглэх бөгөөд бага талбайн элсний гадаргыг элсний зохих Тэмдгээр зурна.

Дэллэсэн сэвхүүл элсийг дүрслэхэд Тэмдгийн байрлал нь элсний газар дээрх тогтоцтой (чиглэгчтэй) тохирч байх ёстой. Манхан элсний Тэмдгийн байрлал нь орон нутагт ноёлох салхины чигтэй адил байна.

Элсний Тэмдгийн дэргэд элсний төрөл, тогтцын өндөр зэргийг бичнэ. Жишээ нь: дэл элс, дэлийн өндөр 10-15 м (нэг тоот нь 1-1.5 дм.кв), (тэгш, довцог, хонхорцгон гэх мэт) байна.

130-131 /F203_A – F203_P/. Говьд тохиолддог ямар ч ургамалгүй хуурай, ан цав суусан шаварлаг хөрстэй, хавтгай хэлбэрийн хотгор, хуурай газар нь шал юм. Ийм газар нь заримдаа богино хугацаанд устай шавраар хучигдах ба бусад хугацаанд хуурай гадаргатай, олон хэлбэрийн өнцөг үүсгэсэн хагаралтай байна. Зургийн масштабт 25 мм.кв-аас бага талбайтай шалыг нэг зураасан Тэмдгээр, хүрээгүй, дэвсгэр өнгөгүй зурна.

132 /F204_A/. 1:25 000-ны масштабтай байр зүйн зурагт 1 см.кв-аас багагүй талбайд дүрслэгдэх шавар, шавранцар хөрстэй талбайг дүрслэх Тэмдэг. Шаварлаг гадаргыг байр зүйн зурагт үзүүлэхэд шавар, шавранцар төрлийн ургамалгүй газрыг хамааруулна. Ийм гадарга өргөн уудам газар нутгийг хамарсан тал хээрийн (хаялбараар илэрхийлэгдэх) говь газар хамаарагдах ба зарим газар нутагт тухайлбал өндөрлөг ба томоохон ганга жалгатай газар ч тохиолдоно.

133-134 /F205_A – F205_P/. Сул чулуутай ба сайр чулуутай газар нь байршлын хувьд хоёр янз байдаг. Сул чулуу нь ихэвчлэн уулын орой, бэл хяраар байдаг. Сайр чулуу нь тэгш тал, хээр болон говь нутагт ихээхэн талбайг хамарч олонтоо тохиолдоно. Эдгээр Тэмдгийг сийрэг буюу шигүү, модлог болон бутлаг ургамлын бүрхүүлтэй хослуулан хэрэглэж болно. (Жишээ нь: Сул чулуутай сийрэг ой, сайр чулуутай өргөстэй бутлаг ой гэх мэт)

Хайрга, чулуу сайртай болон үйрмэг бутархай чулуутай гадарга нь өнцөг бүхий уулын чулуулгийн бөөгнөрлөөс бүрдэнэ. Сайр чулуутай гадарга нь тал газар тохиолдох ба түрэгдлээс үүсээгүй, хөндлөнгөөрөө 10 см хүртэл хэмжээтэй, хурц өнцөг бүхий чулуутай гадарга байна. Үйрмэг бутархай чулуутай газар нь уулын тэгш орой, бэлд тохиолдох бөгөөд чулуу нь янз бүрийн хэлбэртэй байна. Хэрэв сайр чулуутай, үйрмэг бутархай чулуутай гадарга томоохон талбайтай, бусад гадаргатай нийлж байвал тэдгээрийг зааглан хязгаарлаж "сайр чулуу", буюу "сайр чул.", "үйрмэг бутархай чулуу" буюу "үйр.бут.чул." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

135 /F207_A/. Чулуутай гадаргын Тэмдгийг зургийн масштабт 1 см.кв-аас багагүй талбайг эзлэх уулын чулуулагтай газрыг ялгахад хэрэглэнэ. Ургаа

чулуутай хатуу чулуулаг, бүхэл чулуун гадаргыг байр зүйн зурагт тухайн гадарга нүцгэн эсвэл салхины үйлчлэлээр хэд хэдэн см царцсаар хучигдсан тохиолдолд үзүүлнэ. Ийм гадаргын хаднаас ялгагдах онцлог нь огцом налуу багатай, хэсэг хэсгээр тогтоогүй байдаг. Тэдгээрийн Тэмдгийг хаялбартай давхцуулан зурж болохгүй. Хэрэв ийм гадаргын хязгаар сайтар мэдэгдэж байвал зааглана. Заримдаа бүхэл чулуун гадарга дээр цөөн тооны бут сөөг бусад ургамал ургасан байх тул түүний Тэмдгийг хослуулан тэмдэглэж үзүүлнэ.

136 /F208_A/. Говьд тохиолддог дов маягийн тогтцын Тэмдэг. Дунджаар хөндлөнгөөрөө 5-10 м, өндрөөрөө 1-3 м хэмжээтэй дов довцгийг тухайн масштабд болон хаялбарын огтлолоор байр зүйн зурагт илэрхийлэгдэж чадахгүй. Дов довцгийн орой нь бөмбөгөр эсвэл хавтгай байна. Дов довцог бүхий гадаргыг тэмдэглэхдээ элсэн дов довцог гэх мэт ижил төстэй, бичил хэлбэрийн гадаргыг хамтатган үзүүлж болохгүй. Дов довцогтой газар нь давс, намаг, ургамалтай бол Тэмдгийг хослуулан дүрсэлнэ.

137 /F209_A/. Дов сондуул бүхий гадаргын Тэмдгийг чийглэг шаарддаг тачир өвстэй ширэг, ургамлаар бүрхэгдсэн, бага хэмжээний довцогтой гадаргыг байр зүйн зурагт үзүүлэхэд хэрэглэнэ. Эдгээр гадаргыг зургийн масштабд 1 см.кв-аас их талбайтай зааг хязгаар, бичил хэлбэрт гадаргын 0.3-0.7 м өндрөөр хэмжигдэнэ. Дов сондуултай гадарга нь тээврийн хэрэгслээр туулахад хүндрэлтэй бол 0.3-0.5 м өндөр эсвэл 0.5 м-ээс өндөр гэх мэт тайлбар бичиглэл өгнө.

### 8.20 Газрын гадарга дээрх байгууламж

8.20.1 Гол мөрөн эсвэл сувгийн усыг хааж усны түвшинг дээшлүүлэхэд зориулагдсан усан сан үүсгэх хаалтыг далан гэнэ. Мөн хийц материалын хувьд төмөр, чулуун, модон, бетон, төмөр бетон, шороон гэх мэт байдаг.

8.20.2 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

138-140 /F301_A – F302_L/. Далан /овоолго шороо/ нь гол төлөв зам тээврийн байгууламж болох бөгөөд мөн өндөрлөгдсөн, гидротехникийн байгууламж юм. Эдгээр нь нам дор газрыг усанд автагдахаас хамгаалахад зориулагдана.

Тухайн масштабаас шалтгаалан даланг хоёр ба дан тасархай зураасаар үзүүлнэ. Усны урсгал дагуу баригдаж буй шороон түрц, далан хаалтыг байр зүйн зурагт дараах нөхцөлд Тэмдгээр үзүүлнэ. Тухайлбал:

- далангийн урт байр зүйн зурагт 3 мм ба түүнээс их бол;
- далангийн өндөр бодит байдлаар 0.25 м-ээс их, байр зүйн зураг 0.5 м эсвэл 1 м-ийн үеийн өндөртэй бол;
- далангийн өндөр 1 м ба түүнээс өндөр, байр зүйн зураг 2 м ба 5 м-ийн үеийн өндөртэй бол

Даланг хэлбэр хэмжээ, байрлалаар нь байр зүйн зурагт үзүүлэхээс гадна бэхэлгээтэй, бэхэлгээгүй, ямар материалаар хийгдсэнийг мэдээлэлд оруулж өгнө.

100 м урттай болон зарим далангийн тодорхойлолтыг Тэмдгийн дэргэд бичнэ. Уг үзүүлэлтэд: байгууламжийн материал (ТБ-төмөр бетон, Газ-газар, Ч-чулуу), далангийн дээд хэсгийн урт, өргөн (м), усны дээд, доод түвшин, дээгүүр нь зам явдаг даланд замын хашлаганы өндөр зэргийг бичнэ. Усан доорх даланд усны дээд, доод түвшинг бичнэ.

Ус ашиглах техникийн барилга байгууламжийн далангийн техникийн үзүүлэлтийг нь нэлээд дэлгэрэнгүй бичнэ. Усны болон бусад далангийн материал, далангийн устай хэсгийн болон нийт далангийн урт, далангийн дээд өргөн зэрэг болно. Харин усны дээд, доод түвшний тоотын оронд тэдгээрийн ялгаврыг бичнэ.

1:25 000, 1:50 000-ны масштабтай байр зүйн зураг дээр өргөн нь тухайн масштабд илэрхийлэгдэхгүй даланг хөндлөн зураастай хоёр шулуунаар зурна. 1:100 000-ны байр зүйн зурагт бүх даланг (зургийн масштабд илэрхийлэгдэхгүй) хөндлөн зураастай нэг шулуунаар зурна. Далангаар хүрээлсэн гол, суваг нь хоёр шулуунаар дүрслэгдэх бол далан хоорондох зайд усан гадаргын дэвсгэр өнгө өгнө. Хэрэв далан нэг талдаа байвал нөгөө талд нь эргийн шугамыг дүрсэлнэ. Нэг шулуунаар дүрслэгдэх хашлага гол болон 0.16 мм буюу 0.2 мм өргөн нэг шулуунаар дүрслэгдэх суваг, шуудууг тогтоосон тэмдгээр нь, хашлага, далан хооронд Тэмдгийн дотор үзүүлнэ.

141-142 /F303_L – F304_L/. Ус зайлуулах зориулалтаар хийгдсэн суваг, шуудууг ямар нэг өөрчлөлтгүйгээр /налуу, эгц/ тухайн масштабын байр зүйн зурагт бодит байрлалаар нь оруулна.

143 /F305_P/. Түүхийн холбогдолтой хиргисүүр газрыг байр зүйн зурагт тодорхой тохиолдолд "эрт." - эртний, "булш", "түүх."-түүхийн гэх мэт тайлбар бичиглэлтэй үзүүлнэ.

144 /F306_P/. Овоолсон хөрс, шороо, овоолгын Тэмдгээр үйлдвэрлэлийн ашигт малтмалын хураасан овоолго хаягдлыг тэмдэглэнэ.

Ухсан газар гэдэгт ил аргаар ашигт малтмал ашиглаж байсан (үйлдвэрийн зориулалтын бус) газар ухах техникээр газрын хөрсийг хуулсан гэх мэт газрыг хамааруулна. Хотгор гүдгэрийн нэгэн элемент болох нүхийг байр зүйн зурагт хоёр дүрслэлээр үзүүлнэ:

- байгалийн үүсэлтэйг хүрэн, хүний гараар бүтсэнг хар өнгөөр тус тус дүрслэн зурна.

145 / F307_P/. Овооны Тэмдгийг байгалийн тогтоцтой буюу хиймэл овоо, довыг тэмдэглэхэд хэрэглэнэ.

146-147 /F308_P – F308_A/. Оршуулгын газрыг дунд масштабын байр зүйн зурагт масштабын болон масштабын бус тэмдгээр дүрсэлнэ.

Оршуулгын газрын масштабын бус Тэмдэг нь 2 мм талтай тэгш өнцөгт байх бөгөөд газар дээрх чигээр нь байрлуулж *"орш.газ."* гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

148 /F309_P/. Эртний барилга байгууламж, сүм хийдийн туурийг уг Тэмдгээр дүрслэн "*туурь.*" гэсэн тайлбар бичиглэл хийнэ.

149 /F310_L/. Түүхийн холбогдолтой хана (Эрдэнэзуугийн хана гэх мэт), газар хөдлөлөөс тогтсон байгалийн тогтоцтой газрын гавыг байр зүйн зурагт үндсэн сууриар нь үзүүлнэ. Түүхийн холбогдолтой ханыг зурагласан бүх байр зүйн зурагт "түүх." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө.

150-151 /F301_T, F307_T/. Далан, сувгийн үзүүлэлт, газрын гадарга дээрх байгууламжийн тайлбар бичиглэл эдгээр давхаргад бичигдэнэ. Жишээ нь: *шороо, хирг., овоо, овоол.*

### 8.21 Ургамал зүй

8.21.1 Газар дээр сайн ялгарах ургамал, хөрс, тарианы талбайн хилийг цэгээр зурна. Цэгийг нэгэн жигд байрлалаар адил хэмжээтэй зурна.

8.21.2 Ургамлыг байр зүйн зурагт дүрслэхэд: модлог-өндөр голчтой ердийн ой, нам ургасан жижиг ой, суулгасан өндөр голчтой ой, ойн залуу суулгац, мод үржүүлгийн ой, ой хамгаалах зурвасын модлог суулгац, шатсан ба хөрөөдөж буулгасан ой, сондгой мод, бутлаг ба хагас бутлаг бут сөөг; өвслөг-тодорхой үндэсгүй үргэлжлэн ургасан, хөвд хаг, өвслөг ургамал болон усны ургамлууд гэх мэт ангилна. Ойн Тэмдгийг тогтмол үржүүлдэггүй, зэрлэг /байгалийн/ модлог ойг дүрслэхэд хэрэглэх нь зүйтэй.

8.21.3 Төрөл бүрийн ургамалтай газрын зааг нь тодорхой бус бол (мөн хөрс нь) шилжилтийн заагийг үзүүлэхэд ургамлын Тэмдгийг хольж тэмдэглэж болно.

8.21.4 Тачир ой гэдэгт байгалийн таатай нөхцөлд (намаг, чулуун хөрс) ургасан бүдүүн модны өндөр нь 6 м-ээс ихгүй байх ойг хэлнэ. Энэ төрлийн ойг зургийн масштабд эзлэх талбай нь 25 см.кв-аас их тохиолдолд ангилж, үзүүлэлтийг нь хамт дүрсэлнэ.
8.21.5 Сийрэг ойн Тэмдгийг, модны орой хоорондох зай завсар нь модны төрлөөс хамаарч 2-5 м байх тохиолдолд хэрэглэх бөгөөд түүнээс их зайд ганц нэг модны Тэмдгийг хэрэглэнэ. Сийрэг ойн Тэмдгийг ургамал, хөрсний бүрхүүл (шавар, шавранцар хөрстэй зулзаган сийрэг ои, бут, өвслөг ургамал гм.)-тэй хослуулан хэрэглэнэ.
8.21.6 Элемент бүрийн онцлогт тохирсон тодорхой шаардлагыг хүснэгтийн харгалзах утгад дэс дугаар, кодтой уялдуулан нарийвчлан тодорхойлов. Үүнд:

152 /D101_A/. Байр зүйн зурагт ойг дүрслэхэд ногоон дэвсгэр өнгө өгнө. Бүдүүн суулгац ой, өргөн зурвасын суулгац ой, нэгэн төрлийн болон холимог жимсний мод, техникийн зориулалттай модлог ургамлын тариалан зэргийг ногооноор будаж Тэмдэг дүрслэлээр үзүүлнэ. Зулзаган мод, залуу суулгац, хэвтээ ургамал, хулс, заг, өргөст болон бусад бут сөөг, жимс, техникийн болон бутлаг ургамлын тариалан, зүлэг зэргийг ногоон өнгөөр үзүүлж, графикаар дүрсэлнэ.

153 /D101_P/. Зургийн масштабд илэрхийлэгдэхгүй шилмүүст, навчит, холимог төгөл, ганц нэг модны Тэмдгийг газар орчинд сайн чиг баримжаа болох төгөл модонд хэрэглэнэ.

154 /D102_L/. Ургамлыг тархац, хил хязгаарыг зааглан үзүүлэхэд уг цэгэн хүрээн Тэмдгийг ашиглана.

155-156 /D103_P – D104_P/. Ойн зонхилох модыг тэдгээрийн бүтэц, өндрийг метрээр тэмдэглэн байр зүйн зурагт үзүүлнэ. Бүтцийг навчит, шилмүүст гэж ангилна. Нэг төрлийн мод нь бүх модны 80-аас ихгүй хувийг эзэлж буй үед холимог ой гэж бичнэ. Энэ тохиолдолд тэдгээрийн Тэмдгийн зүүн талд товчлоогүй тайлбар бичиглэл өгнө. Гол нэрийг дээд талд, хоёр дахь нэрийг доод талд нь бичнэ. Модны өндрийг (м-ээр) орой хүртэл, бүдүүний хэмжээг хүний цээжний түвшинд авсан хэмжээгээр үзүүлэх ба мод хоорондын зайг мөн үзүүлнэ. Хэрэв үзүүлэлтийг бичих зай, зурвас бага бол модны өндрийг бичиж болно. Модны бүрдэл, хэмжээний үзүүлэлтийг бичих талбай хангалттай тохиолдолд 1-2 үзүүлэлтийг 1 дм.кв талбайд суулгацын өөрчлөлтийг харгалзан бичнэ.

157 /D106_A/. Намхан зулзаган модтой ойгоор 4 м-ээс ихгүй өндөртэй, өргөжин ургах боломжгүй (намаг, чулуун хөрс гэх мэт) газарт ургасан, нас гүйцсэн модыг зурна. Зулзаган ой, ойн суулгац, тарьц зэргийг шилмүүст, навчит, холимог ой гэж ангилан зурна. Голлох модны төрлийг нэрлэж үзүүлэлтийг бичнэ. Эдгээр ойд зонхилох модны Тэмдгийн дундаж өндөр (м)-ийг 0.1 м нарийвчлалтай бичнэ.

158 /D111_A/. Зулзаган мод зонхилдог сийрэг ой болон зулзаган ойг байр зүйн зурагт үзүүлэхэд /Тайлбар 157/ тайлбарыг баримтална.

159 /D112_A/. Салхи, усан давалгаанд нэрвэгдсэн модны овоолго, дархи модны Тэмдгээр үзүүлнэ. Ийм талбай нь ой модны гүнд зургийн масштабд 25 см.кв, задгай газарт 10 см.кв-аас их талбайг эзэлсэн бол тус тус ялгаж дүрсэлнэ. Хэрэв ой модны тал хувиас арай бага унасан боловч ийм газарт явах ямар ч боломжгүй бол ойг үзүүлж, дархи модны Тэмдэг тавина.

160 /D113_A/. Шатсан, хуурайшсан ойн Тэмдгийг ойн ихэнх талбайд шатсан хуурайшсан мод ихтэй газарт хэрэглэнэ. Шаардлагатай нөхцөлд хатсан ойд "хат." эсвэл "хуур." гэсэн тайлбар бичиглэлийг өгнө. Түймэрт нэрвэгдсэн ойн хэсэг мөчиртэй үлдэх тохиолдол байдаг. Ийм тохиолдолд бүдүүн голчтой болон шатсан ойн Тэмдгийг тухайн талбайг хамруулан хосолмол Тэмдгээр үзүүлнэ. Ойн гэмтсэн (шатсан гэх мэт) талбайд ургасан бут сөөг, бусад ургамлыг байр зүйн зурагт бодит талбайн хэмжээгээр оруулна.

161 /D114_A/. Хожуул ихтэй ойд огтлогдсон ойн Тэмдэг хэрэглэнэ. Энэ Тэмдгийг ургамлын бүрхүүл (өвслөг ургамал, бут буюу зулзаган ой)-тэй хослуулан хэрэглэнэ.

162 /D115_P/. Чиг баримжаа болохгүй ганц нэг модны Тэмдгийг суурин газрын хороолол, барилга байгууламж, ногооны талбай, тариан талбай доторх модыг дүрслэхэд хэрэглэнэ. Сондгой ургасан (ганц мод) модыг байр зүйн зурагт чиглэл баримжаа болох, түүх соёлын гэсэн хоёр утгаар навчит, шилмүүст, жимсгэний болон бусад гэж хуваан Тэмдгээр үзүүлнэ.

163 /D116_P/. Байр зүйн зурагт өвслөг ургамлыг нугын, өндөр өвслөг, чийгийн, талын, зэгсний гэж ангилан үзүүлнэ. Эдгээрээс өндөр өвслөг нь 1 м-3.5 м өндөртэйгөөр ялгагдах ба зэгсний төрлийн ургамал үүнээс өндөр эсвэл нам байх бөгөөд бусад нь 1 м хүрэхгүй өндөртэй байдаг. Эдгээр төрлийг ургамал тус бүрийн Тэмдгээр дүрсэлнэ. Өвслөг ургамлыг эзэлж буй талбайгаар нь эсвэл байрласан зурвасын тэнхлэгээр зурж үзүүлнэ.

164-165 /D117_A - D119_A/. Байр зүйн зурагт бут сөөг, загийг хэсэгчлэн болон нэлэнхийд нь Тэмдгээр үзүүлнэ. Бут сөөг нь газраас шууд мөчирлөсөн байдлаараа болон өндрөөрөө, нас гүйцсэн модноос ялгарна. Бут, сөөг (ердийн болон өргөст)-ний Тэмдгээр өндрөөрөө 0.8-6 м олон наст модлог, газрын хөрснөөс навчилдаг ургамлыг дүрсэлнэ. Нэг буюу хэсэг бут, сөөгийг нэг Тэмдгээр үзүүлнэ.

Шигүү ургасан бут, сөөгт төрлийг нь зааж бичнэ. Дундаж өндрийг 0.1 м нарийвчлалтай (1 м-ээс бага бол), үүнээс өндөр бол бүтэн метрээр бичнэ. Хэсэг хэсгээр ургасан бут сөөгийг байр зүйн зурагт олон хэлбэрээр дүрсэлнэ. Бут сөөгийг олон янзын диаметртэй дугуйгаар зурж үзүүлнэ.

